

“ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Бодлогын судалгаа

2022 он

АМЕР 2 хөтөлбөрийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.

Adam Smith
International

Мэдэгдэл

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэ хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэ тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

Судлаачдын баг/Зохиогчид

“Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо” ТББ

Б.Лхамсүрэн, хуульч

Б.Өлзийбаяр, хуульч

Д.Өлзийбаяр, байгаль орчны мэргэжилтэн

Г.Байгаль, хуульч

Х.Хажидсүрэн, хуульч

Эцсийн тайлан хүлээн авалцсан баримт

Илгээсэн огноо	2022-02-24
Илгээгч	Б.Лхамсүрэн
Хүлээн авагч	
Гарын үсэг	
Батлав	
Гарын үсэг	
Огноо	

Судлаач, гэрээлэгч тайлангийн эхний хувилбарыг АМЭП 2 хөтөлбөрийн Менежерт илгээх бөгөөд илгээсэн хувилбар бүрт дараах хүснэгтийг бөглөсөн байна.

Илгээсэн огноо	2022-01-03
Хэнд	Төслийн менежер
Гарын үсэг	
Хэнээс	Б.Лхамсүрэн

Гарчиг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	2
1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага	2
1.2. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	3
1.3. Үнэлгээний арга зүй.....	4
ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.	5
2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ.....	5
2.2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт	14
2.3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	22
2.4. Газрын хэвлий ашиглахтай холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн ерөнхий дүн шинжилгээ	38
2.5. Хууль тогтоомжийн уялдаа	40
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	41

Зураг, графикийн жагсаалт

Зураг 1. Эвдэрсэн газрын тооллого.....	27
Зураг 2. Швед улсын Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, хяналт болон ашигт малтмалын эрэх, хайх, олборлох, боловсруулах тусгай зөвшөөрөл олгох асуудал хариуцсан газар	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	3
Хүснэгт 2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	4
Хүснэгт 3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	4
Хүснэгт 5. Үндсэн хуулийн хэв загвар	6
Хүснэгт 6. Гарал үүсэл нь тодорхойгүй хайлуур жоншны экспорт	12
Хүснэгт 7. Гарал үүсэл нь тодорхойгүй хайлуур жоншны экспорт	12
Хүснэгт 8. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	15
Хүснэгт 9. Эвдэрсэн газрын тооллогын ажил 2012, 2018. БОАЖЯ.....	16
Хүснэгт 10. Газрын хэвлийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт	18
Хүснэгт 11. Хойд Австрали мужийн уул уурхайн менежментийн тухай хууль	20
Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил.....	22
Хүснэгт 13. Хохирол учирсан талбай, үндсэн ангиллаар, улсын дүн, жилээр	29
Хүснэгт 14. Төрийн байгууллагын чиг үүрэг, уялдаа	31
Хүснэгт 15. Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос бусад зориулалтаар ашиглах	35

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Шүүхийн шийдвэр	44
Хавсралт 2. Хууль тогтоомжийн уялдаа.....	47
Хавсралт 3. Монгол Улсын хуулиудад тусгагдсан хяналтын чиг үүргүүд.....	97

Товчилсон үгийн жагсаалт

АМтХ	Ашигт малтмалын тухай хууль /2006/
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНБУтХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1988 онд Монгол Улсад газрын хэвлий, түүний баялгийг ашиглах, хамгаалах харилцаа нь өнөөдрийнх шиг нийгэм, эдийн засгийн үлэмж үр дагавар бүхий асуудал болох эсэх тодорхой бус нөхцөл байдалд “Газрын хэвлийн тухай хууль” батлагдсан байдаг.

Гэтэл, газрын хэвлийн баялаг ашиглах хувь хэмжээ 1990 онд аж үйлдвэрийн салбарын 35.2 хувь байсан бол 2018 оны байдлаар 67.6 хувь хүртэл өссөн бөгөөд газрын хэвлийн баялгийг ашиглах харилцаа олон талт, тус улсын эдийн засгийн гол салбар болон хувирч, энэ хугацаанд шинэ дутам нийгэм, эдийн засгийн олон сорилт тулгарч, эерэг, сөрөг үр дагавар цөөнгүй гарсан байна.

Газрын хэвлийн тухай хууль нь 1988 онд батлагдсанаас хойш улс орны хууль хууль тогтоомж, эрх зүйн орчин ихээхэн хэмжээгээр өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай хөгжиж байгаагийн улмаас тус хуулийн нэр томьёо, зохицуулалтын хэр хэмжээ, агуулга нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад бүрэн дүүрэн нийцэхгүй, учир дутагдалтай, давхардал, зөрчил болон тодорхой бус асуудлууд агуулагдсаар байгаа байгаа зэрэг болон Монгол Улсын “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэсэн практик хийгээд хуулийн зүйн үндэслэлд тулгуурлан “Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн болно.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ “Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйл заасан “Газрын хэвлийг ашиглах зориулалт” буюу:

- геологийн судалгаа хийх;
- ашигт малтмал олборлох;
- ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;
- аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах.

гэсэн тус хуулийн “зохицуулах харилцаа”-ны дагуу ангилж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.4-д заасан

- Зорилгод хүрсэн түвшин,
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал,
- Практикт нийцэж байгаа байдал, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

“Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зорилт нь тус хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино. “Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээг хийж, гүйцэтгэлээ.

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах алхмуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Үнэлгээ хийх асуудлын онцлогоос шалтгаалан эдгээр алхмуудыг бүгдийг гүйцэтгэх буюу дээр дурдсан дарааллыг ягштал баримтлах шаардлагагүй байж болохыг анхаарав.

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан.

Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хүрээнд геологийн салбарыг хөгжлийг эрчимжүүлэх, улсын эрдэс баялгийн санг тасралтгүй нэмэгдүүлэх, геологийн судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, тус салбарыг түрүүлэн хөгжүүлэх зорилтуудыг тодорхойлсон бөгөөд эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд ашигт малтмалын төрлөөс үл хамааран геологийн судалгааны ажлыг цогцоор нь иж бүрэн хийж гүйцэтгэх үндэсний геологийн албыг олон улсын жишгээр байгуулж, удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг нэгдмэл, оновчтой болгож тогтвортой ажиллуулахаар заасан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсан. Тус тогтоолын 1.1-д “Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай заасан байна.

Нөгөө талаас, хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Газрын хэвлийн тухай” хууль нь 1988 онд батлагдсанаас хойш эдүгээ улс орны хууль тогтоомж, эрх зүйн орчин ихээхэн хэмжээгээр өөрчлөгдсөн, нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай хөгжиж байгаагийн улмаас тус хуулийн нэр томъёо, зохицуулалтын хэр хэмжээ, агуулга нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад бүрэн дүүрэн нийцэхгүй, учир дутагдалтай, давхардал, зөрчил болон тодорхой бус асуудлууд агуулагдсаар байгаа зэрэг нь тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хууль зүйн болон практик шаардлага байна гэж үзсэн болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Судалгааг гүйцэтгэхдээ хуулийн бүхий л зүйл, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх нь үнэлгээний ач холбогдлыг бууруулдаг. Өөрөөр хэлбэл хэлбэрийн төдий, тулгамдсан асуудалгүй зохицуулалт бүрд үнэлгээ хийснээр судалгааны хүрээ хэт өргөн, судалгааны объект тодорхойгүй, нуршуу болдог. Иймд тус хуулийн хэрэгжилтийг тооцож болохуйц, ач холбогдол бүхий зохицуулалтыг дараах байдлаар сонгон авлаа. Үүнд:

- “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт

3 дугаар зүйл. Монгол Улсын газрын хэвлий бол төрийн өмч

11 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигласны төлбөр

41 дүгээр зүйл. Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага

- “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

9 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглагч

20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг

10 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах зориулалт

13 дугаар зүйл. Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох

- “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох

6 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах

51 дүгээр зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд тавих төрийн хяналтын зорилт

52 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд хяналт тавих байгууллага

53 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлтийг сонгохын тулд шалгуур үзүүлэлт тус бүрийн ойлголт, онцлог, хоорондын ялгааг харгалзан үзэж, сонгосон шалгуур үзүүлэлт нь “Газрын хэвлийн тухай” хуулийн холбогдох хэсэгт үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байх, хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байх гэсэн шаардлагын дагуу дараах дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонгох нь тохиромжтой гэж үзлээ. Үүнд:

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1, 3, 11, 41 зүйлтэй холбогдох асуудал буюу “Газрын хэвлийн тухай” Монгол Улсын хуулийн зорилт, өмч, төлбөр, хамгаалах” талаар судлахаар сонгосон. Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг энэ үзүүлэлтээр тогтооно.

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйл.	Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт
2	3 дугаар зүйл.	Монгол Улсын газрын хэвлий бол төрийн өмч
3	11 дүгээр зүйл.	Газрын хэвлийг ашигласны төлбөр
4	41 дүгээр зүйл.	Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага

“Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 9, 20, 10, 13 дугаар зүйл буюу “Газрын хэвлийг ашиглагч, үндсэн эрх, үүрэг, ашиглах зориулалт, Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгохтой холбогдох асуудлыг судлахаар сонгосон болно. Иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр

дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

Хүснэгт 2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	9 дүгээр зүйл.	Газрын хэвлийг ашиглагч
2	20 дугаар зүйл.	Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг
3	10 дугаар зүйл.	Газрын хэвлийг ашиглах зориулалт
4	13 дугаар зүйл.	Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 12, 6, 51, 52, 53 зүйлтэй холбогдох асуудлыг судлахаар сонгосон. Тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

Хүснэгт 3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	12 дугаар зүйл.	Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох
2	6 дугаар зүйл.	Газрын хэвлийг ашиглах, хамгаалах
3	51 дүгээр зүйл.	Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд тавих төрийн хяналтын зорилт
4	52 дугаар зүйл.	Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд хяналт тавих байгууллага
5	53 дугаар зүйл.	Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх

“Зардлын өсөлт, бууралт” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ... буюу зохицуулалтын асуудлыг судлахаар сонгосон. Хууль тогтоомж хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүсэж байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно. Энэ шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор зардал өссөн, эсхүл буурсан өөрчлөлтийг гаргах үүднээс томъёолно.

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг ерөнхийд нь баримтлан хийж гүйцэтгэв. Түүнчлэн “Газрын хэвлийн тухай” хуулийн дээр дурдсан зүйл, заалтуудын хэрэгжилтийг судлахдаа эрх зүйн харьцуулалт хийх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх гэсэн хууль зүйн шинжлэх ухааны судалгааны аргуудыг ашигласан болно. Түүнчлэн, олон улсын тэргүүн туршлага харьцуулсан судалгаа, гарын авлагаас гадна, төрийн албан хаагчид, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс авсан ярилцлагын судалгааны үр дүнг ашигласан болно.

ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.

2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Газрын хэвлийн тухай” хуулийн 1, 3, 11, 41 дүгээр зүйлтэй холбогдох асуудлыг судлахаар сонгосон. Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг энэ үзүүлэлтээр тогтооно.

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Монгол Улсын газрын хэвлий бол төрийн өмч

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн.

Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.

11 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигласны төлбөр

1. Газрын хэвлийг төлбөртэй ашиглана.
2. Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно.

41 дүгээр зүйл. Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага

1. Монгол Улсын газрын хэвлий нь улсын хамгаалалтад байна.
2. Газрын хэвлийг хамгаалахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

- 1/газрын хэвлийн геологийн судалгааг иж бүрэн гүйцэд хийх;
- 2/газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх, түүнийг дур мэдэн ашиглах явдлыг гаргуулахгүй байх;
- 3/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийг зөв зохистой, иж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах;
- 4/ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах;
- 5/ашигт малтмалын ордыг усанд автах, үер, гал түймрээс болон ашигт малтмалын чанар, ордын үйлдвэрийн үнэт чанарыг бууруулах буюу түүний ашиглалтыг хүндрүүлж болох бусад хүчин зүйлээс сэргийлэн хамгаалах;
- 6/ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барих, уг талбайг ашиглах талаар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх;
- 7/ашиглаж байгаа болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооног, түүнчлэн газар доорхи барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг газрын хэвлий ашиглах явцад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хамгаалах.
- 8/газар доор нефть, хий, материалыг хадгалах, хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах үед газрын хэвлий бохиртохоос сэргийлэх.

БНМАУ-ын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн зарлигаар тухайн үед газрын харилцаа, ашигт малтмал хайх, олборлох, газрын гүнд барилга байгууламж барих үйл ажиллагаа, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах харилцааг зохицуулах зорилгоор “Газрын хэвлийн тухай” хууль-ийг баталсан байна.

Харин 1990 онд Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр шинэ нийгмийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх

зорилгоор тус хуульд 1994 онд зарчмын шинжтэй гол нэмэлт өөрчлөлтийг оруулсан байдаг.

Газрын хэвлийн тухай хуулийн зорилго, түүний зохицуулах харилцаа, суурь эрх зүйн эх сурвалж гэдэг ач холбогдлыг нь тодотгох үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд хэрхэн туссан байдаг тухай онол болон практик үндэслэлийг товч судалж үзье.

Аливаа улсын Үндсэн хууль бол тухайн ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, хамтран амьдрах гэрээ болохын хувьд нийтлэг үнэт зүйл-зорилгыг хамгийн эхэнд тусгасан байдаг.

Судлаачид Үндсэн хуулийн үзэл баримтлалыг судлан дэлхийн улс орнуудыг (1) Либерал, (2) Хөтөлбөр, (3) Түгээмэл хандлага бүхий Үндсэн хуультай гэсэн гурван загварт хуваан авч үздэг.¹

Хүснэгт 4. Үндсэн хуулийн хэв загвар

Либерал	Түгээмэл	Хөтөлбөр
Цэвэр Процедурын үндсэн хууль	Процедурын болон Хөтөлбөр Үндсэн хуулийн дундын хувилбар	Цэвэр Нийгмийн Үндсэн хууль

Аливаа улс төрийн үзэл номлолын цаана эцэстээ өмчийн харилцааны асуудал хөндөгддөг. Либерал Үндсэн хуультай улсад нийтийн эзэмшлээс бусад хувийн газар өмчлөх эрх нь газрын гадаргуугаас гадна түүний хэвлийд буй баялгийг хамаардаг.

Эсрэгээрээ Хөтөлбөр Үндсэн хуультай буюу Реалист улс төрийн номлолтой улсад амины өмчөөс бусад нь төр, олон нийтийн өмч хэмээн үздэг.

Харин Түгээмэл Үндсэн хуультай буюу Конструктивист² улс төрийн номлолтой оронд газрын гадаргуу л зөвхөн тухайн иргэний эзэмшил, өмчлөлд хамаараахаас биш, газрын хэвлий дор байгаа баялаг бол нийт ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байдаг.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал ямар учраас түгээмэл хандлага гэсэн ангилалд орсныг нотлохын тулд Үндсэн хуулийн дараах заалтуудыг иш татъя.

Монгол улсын 1992 оны Үндсэн хуулийн Бүрэн эрхт байдлын нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 1-д :

"Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ."

Тавдугаар зүйлийн 1-д:

"Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.", Мөн зүйлийн 2-т *"Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална."*... хэмээн улс төр - эдийн засгийн либерал зарчмуудыг тунхаглажээ.

Тавдугаар зүйлийн 4-д:

¹ David S. Law, Constitutional Archetypes, Texas Law Review, 2016, 160-182p.

² Charles W. Kegley, Shannon L. Blanton, World Politics Trend and Transformation, 2011, 29-50 p.

"Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна."

Зургаадугаар зүйлийн 2-д:

" Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн." ...гэсэн заалтаас үзэхэд

Монголын ард түмэн 1992 оны Үндсэн хуулиар төрийн зохицуулалттай, олон хэвшил бүхий эдийн засагтай орон байхаар тунхагласан нь дан ганц хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн **"цэвэр либерал"** болон зөвхөн төр-нийгмийн эрх ашгийг хамгаалсан **"туйлширсан хөтөлбөр"** үзэл баримтлал бүхий үндсэн хуулиас татгалзаж, харин энэ хоёр хэв загварын аль алины онцлогийг шингээсэн **"түгээмэл" хандлагыг** сонгожээ.

Үндсэн хуулийн "түгээмэл" загвар нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хууль-тогтоомжийг өөрийн үндсэн хуулийн дээд эх сурвалж хэмээн үздэг. Энэ утгаараа газрын хэвлий нь "онцгой өмч" бөгөөд "Онцгой өмч" гэдэг бол зөвхөн төр өмчилдөг өмчийн төрөл юм.³

Гагцхүү газар "онцгой өмч" учраас ард түмний мэдэл гэдэг бол хуулийн ойлголт буюу олон улсын ойлголтоор тухайн улсын нутаг дэвсгэрийн эзэн нь тэр орны ард түмэн байх тухай, өөрөөр хэлбэл, ард түмний суверенитетийн асуудал юм. Учир нь аливаа улсыг тусгаар улс гэж тооцох олон улсын эрх зүйн үндэслэл нь "газар нутаг, хүн ам, бие даасан төр засаг"-тай байх суурь нөхцөл болдог.

Иймээс газрын хэвлийтэй холбогдох харилцаанд тусгай дэглэм үйлчилдэг бөгөөд түүний хэвлий, байгалийн баялаг нь улсын тусгаар тогтнолын нэг суурь нөхцөл буюу нутаг дэвсгэртэй салшгүй холбоотой учраас төр хамгаалдаг бөгөөд нутаг дэвсгэрийн эзэн нь ард түмэн тул ард түмний мэдлийн, бүрэн эрхт байдлын асуудалд хамаардаг.

УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 09-нд баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд 1992 оны Үндсэн хуулийн 6.2-т байсан "төрийн өмч" гэсэн агуулгыг "Төрийн нийтийн өмч" гэж тодотгосон. "Төрийн нийтийн өмч" гэж заасны агуулга нь Үндсэн хуулийн 6.2-т оруулсан бусад нэмэлт, өөрчлөлтөөр нарийвчлан тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл, энэ зүйлд төрийн нийтийн өмчид хамаарах газрын хэвлийн болон бусад баялгийг ашиглахад нийтийн ашиг сонирхлын үүднээс буюу "урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах," "одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах," "газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ...тэгш, шударга хүртээх," "газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх"-ийг иргэнд эдлүүлэх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигласны үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх" гэсэн зарчим баримтлахыг заасан.

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1) Монгол Улсын газар, 2) газрын хэвлий, 3) ой, 4) ус, 5) амьтан, 6) ургамал, 7) байгалийн бусад баялаг ард түмний мэдэлд байхаар заасан нь Үндсэн хууль дахь "төрийн нийтийн өмч" гэх нэршлийн "нийт" гэх ойлголтын хүрээ хязгаарыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Энэ заалтыг тус хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй хамтатган хэрэглэвэл газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан нь Монгол Улсын нийт ард түмний мэдлийнх агаад эдгээр өмчийг төр төлөөлөн удирдах боломжтойг илтгэсэн байна.

³ Б.Чимид, БНМАУ-ийн Ардын Их Хурлын хуралдааны протокол, Дугаар 45, 1991.12.30, 9

Газар, газрын хэвлийн орон зай, баялгийн хамт, ой, усны нөөц, ан амьтан сонгодог утгаараа Монголын ард түмний өмч мөн хэдий ч ард түмэн Үндсэн хуулиараа өмчлөгчийн эрхийг түүнийг төлөөлөн төр хэрэгжүүлэхийг зөвшөөрчээ. Ингэхдээ тодорхой хөрөнгө буюу газрын хэвлийн баялаг, ашигт малтмалын хувьд онцгой нөхцөл болзлуудыг заасан нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4, 5 дугаар заалтад тусгагдсан байна.

Иймд 1990 оноос өмнө газар, түүний хэвлий хамтдаа төрийн өмч байсан “хөтөлбөр” Үндсэн хуулийн үйлчлэл дор батлагдсан “Газрын хэвлийн тухай” хууль” нь Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн Хуулиар газрын гадаргыг Монгол Улсын иргэн өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч, зөвхөн “газрын хэвлий”-тэй холбоотой харилцааг зохицуулах агуулгын өөрчлөлт орсон байдаг. Улмаар тухайлсан салбар болон ашигт малтмалын төрлөөр дагнасан, нарийвчлан зохицуулсан дараах хуулиуд батлагдсан байдаг.

- Газрын тухай
- Ашигт малтмалын тухай
- Газрын тосны тухай
- Цөмийн энергийн тухай
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай
- Усны тухай
- Барилгын тухай
- Байгаль орчныг хамгаалах тухай
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 1 дүгээр зүйлд *“Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино”* гэж заасан зорилтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхийн тулд

Нэгд: тус хууль батлагдсанаас хойш буюу өнгөрсөн 34 жилийн хугацаанд газрын хэвлийн ашиглалтын үр дүнг үнэлэх,

Хоёрт: газрын хэвлийг хамгаалах үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх аргаар зорилтын хэрэгжилт, үр дагаврыг тодруулж болно.

Газрын хэвлийн тухай ойлголт

Монгол Улсын Үндсэн хуульд *“...газар, түүний хэвлий ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна, газрын хэвлий төрийн нийтийн өмч мөн, бэлчээр нийтийн эдэлбэр ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг Монгол улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй”* хэмээн газрын хэвлийг өмчлөх, ашиглах харилцааны эрх зүйн үндсийг хуульчилсан байдаг бол “Газрын хэвлийн тухай” хуулиар газрын хэвлийг ашиглахтай холбоотой суурь харилцааг зохицуулжээ.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1.1-т “газрын хэвлий гэж хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс түүнчлэн барилга байгууламж” гэж тодорхойлжээ. Харин Газрын тухай хуульд 3.1.1-т “газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг” хэлнэ гэсэн нь газар болон газрын хэвлий гэх ойлголт эрх зүйн хувьд тусдаа бие даасан ойлголт гэдгийг илтгэж байна.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1 заасан “газрын хэвлий” гэсэн нэр томъёог тайлбарлахад “хөрс” гэх ухагдахууныг тайлбарлах хэрэгцээ шаардлага үүснэ.

“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 4.1.1-д *“Хөрс” гэж газрын гадаргын өнгөн хэсгийн үржил шимт давхарга бүхий дэвсгэр хэсгийг хэлнэ* гэж тодорхойлжээ. Хөрс нь газар зүйн байрлал, эко системээс хамаарч бүтцийн хувьд


харилцан адилгүй, говийн хөрс, хангайн хөрс, гол нуурын ай савын хөрс гээд ялгаатай ба зарим газар огт хөрсгүй буюу хурдастай газрууд хүртэл бий.

Эрх зүйн үүднээс авч үзвэл газрын гадарга, түүний хөрс хэсэг нь газрын тухай хуулийн “газар” гэх ойлголтод хамаарч байна. Харин “Газрын хэвлийн тухай” хуульд газрын хэвлийг хөрснөөс хамааруулж тодорхойлсон нь газрын хэвлийг ашиглах асуудал, “Газрын хэвлийн тухай” хуулийн хүрээ, хязгаарыг тодорхойлж хэрэглэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж байгаа юм. Газрын хэвлийг ашиглах тохиолдолд тухайн этгээд газар ашиглаж байгаа юу эсвэл газрын хэвлий ашиглаж байна уу гэдгийг тодорхойлох шаардлага үүснэ. Ингэж тодорхойлох нь газар доор юу барьж ашиглахаас хамаараад газрын хэвлийг ашиглах зөвшөөрөл авах эсэх, хэрхэн ашиглах, төлбөр төлөх гээд тодорхой үр дагавар үүсгэнэ.

Монгол Улсын ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 1990 онд 35.5 хувь байсан бол 1999 онд 19.3 хувьд хүртлээ буурч, 2000 оноос тасралтгүй нэмэгдсээр 2006 онд хамгийн их буюу 36.5 хувийг эзэлж байсан. Аж үйлдвэрийн салбарын 2018 оны нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг 1999 онтой харьцуулахад 15.7 пунктээр их, 2006 онтой харьцуулахад 1.5 пунктээр бага байна. 2018 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувь 67.6 хувийг эзэлж байна.

Өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 1990 оноос 2018 оны хооронд авч үзвэл 1990 онд хамгийн бага буюу 35.2 хувь байсан бол 2006 онд хамгийн их буюу 77.9 хувь байжээ.⁴ (График 1)

График 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт дэд салбарын эзлэх хувь



Ийнхүү газрын хэвлийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа 35.2 хувиас 77.9 хувь хүртэл тэлсэн нь тус салбарт шинэ дутам нийгэм, эдийн засгийн харилцаа бий болж, олон сорилт тулгарч, эерэг, сөрөг үр дагаварт хүргэжээ.

1990 онд Монгол Улсад өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд үйл ажиллагаа эрхлэх боломж бүрдсэн бөгөөд тус салбарт хөрөнгө оруулалт татах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор цөөнгүй төсөл, хөтөлбөр санаачлан, газрын хэвлийн баялгийг судлах, ашиглах харилцааг зохицуулахаар 1994, 1997, 2006 онд тус тус “Ашигт малтмалын тухай” хуулийг баталсан байдаг.

⁴ www.1212.mn

Газрын хэвлий нь “ард түмний мэдэл, төрийн өмчлөл хамгаалалтад” оршдог “онцгой өмч”-ийн төрлийн хувьд түүний баялгийг ашиглах тохиолдолд “хариу төлбөртэй байх” зарчим үйлчилдэг бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 1,2-д

- “Газрыг хэвлийг төлбөртэй ашиглана”
- “Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно”,

гэж хуульчилсан боловч төлбөр тооцох эсэх нь газрын хэвлийг ашиглах зорилго, зориулалтаас хамаардаг олон улсын болон үндэсний эрх зүйн практик бий.

Тодруулбал, 2006 оны Ашигт малтмалын тухай хуульд 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт орохоос өмнө тус хуулийн 7.5.-д:

- “Газар өмчлөгч, эзэмшигч нь тухайн газарт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр, өөрийн ахуйн хэрэгцээнд ашиглаж болох бөгөөд ийм ашигт малтмалын жагсаалтыг Засгийн газар батална”,
- гэсэн заалт үйлчилж байсан бол 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 20.2.-д:
- “Газар өмчлөгч, эзэмшигч нь тухайн газарт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд ашиглаж болно” хэмээн төрөлжсөн хуульд суулгаж өгсөн байдаг.
- Тэгэхээр нэгд, газар өмчлөгч, эзэмшигч нь тухайн газарт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд ашиглах хэлбэрээр газрын хэвлийг төлбөргүй ашиглаж болох хууль зүйн үндэслэл байна.
- Хоёрт, газрын хэвлийг төлбөртэй болон болон төлбөргүй ашиглах эрх нь ашиглалтын “зориулалт”-аас хамаарахаар хуульд заасан үндэслэл бий.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйл заасан “Газрын хэвлийг ашиглах зориулалт” буюу тус хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар хуульчилсан байна:

1/ геологийн судалгаа хийх;

2/ ашигт малтмал олборлох;

3/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;

4/ мөн тус хуулийн 15.3-д Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй.

Газрыг хэвлийг ашиглах харилцаа төлбөртэй байх эсэх нь дээрх хуульд заасан зориулалтаас хамаарах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын “үндсэн” үйл ажиллагаа газрын хэвлийг ашиглаж “ашиг орлого” олох зорилго бүхий бол төлбөр төлөх, бусад тохиолдол буюу газрын хэвлий ашиглах харилцаа нь үндсэн үйл ажиллагаанд туслах, шууд бус хавсарга шинжтэй бол төлбөр үл тооцох зарчим үйлчилж байна.

Тухайлбал, Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан газрын хэвлийг дараах хэлбэрээр ашиглаж байна. Үүнд:

Иргэд ахуйн хэрэгцээндээ:

- Зоорь барих
- Нүхэн жорлон, угаадасны нүх
- Худаг гаргах
- Усан сан барих
- Барилга байшингийн суурь
- Хог хаягдлыг булшлах

Аж ахуйн нэгж, байгууллага:

- Агуулах, зоорь
 - Барилгын суурийн хэсэг, гараж
 - Оршуулга
 - Дулааны шугам
 - Цэвэр усны шугам
 - Кабель, холбооны шугам
 - Туннель –хонгил, хоолой, нүхэн гарц
- Цооног гаргах зэрэг хэлбэрээр ашиглаж байна.

(Дэлгэрэнгүй судалгааг “газрын хэвлийг ашигт малтмал ашиглахаас өөр зориулалтаар ашиглах” гэсэн хэсгээс үзнэ үү!)

Газрын хэвлийн баялаг ашигласны төлбөрийг ашигт малтмал олборлох салбарт “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” хэлбэрээр авдаг бөгөөд Газрын хуулиар тогтоосон газрын төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс ялгаж ойлгох нь зүйлтэй юм.

Газрын төлбөр нь газрын хэвлийг ашиглах төлбөрөөс объектоороо ялгаатай бол тусгай зөвшөөрлийн төлбөр нь үйл ажиллагаа явуулах онцгой эрхийн төлбөр байдаг онцлогтой.

Газрыг хэвлийн төлбөр буюу АМНАТ тухай

1950-иад оныг хүртэл ашигт малтмалын татварын гол суурь нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) буюу “Royalty” байсан бол тавиад оноос хойш АМНАТ болон ААНОА татварын хослолыг дэлхий нийтээр зэрэг хэрэглэж байна. АМНАТ нь ашигт малтмалын нөөцийг ашиглах эрх олгосны төлөө тухайн орны Засгийн газарт ашигт малтмал ашиглах эрх олгогдсон хуулийн этгээдээс төлөх ёстой төлбөр (татвар биш) юм. Тухайн орны ашигт малтмалын нөөц нөхөн сэргээгдэхгүй тул энэ нь ямар ч хуулийн этгээдэд үнэ төлбөргүйгээр ашиглагдах ёсгүй гэсэн утгыг АМНАТ агуулдаг.

ГЕГ-ын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын мэдээгээр 2019 онд нийт **189** хуулийн этгээд ашигт малтмал экспортолсноос ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 117, тусгай зөвшөөрөлгүй **72** хуулийн этгээд ашигт малтмал экспортолсон байна. Эдгээр тусгай зөвшөөрөлгүй ашигт малтмал экспортлогч этгээдээс 63 аж ахуйн нэгж нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулж, төсөвт төлөөгүй ба тухайн экспортолж буй ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу /тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас олборлосон эсэх, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө төрийн захиргааны байгууллагаар баталгаажсан эсэх гэх мэт/ олборлосон эсэхийг ГЕГ-аас шалгаж тогтоохгүйгээр гаалийн бүрдүүлэлт хийж, ашигт малтмалыг экспортлуулж байна.

Үүнээс шалтгаалан Улсын хэмжээнд ашигт малтмалыг хууль бусаар олборлох зөрчил буурахгүй байгаагаас гадна АМТХ-ийн 4.1.7, 4.1.16, 7.3 дахь заалтууд хэрэгжихгүй байна. 2020 оны 04 дүгээр сард авсан судалгаагаар АМГТГ-т 130 баяжуулах үйлдвэр /үүнээс нүүрс 14/ бүртгэлтэй байгаагаас 45 баяжуулах үйлдвэр /үүнээс нүүрс 8/ нь ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй талбайд үйл ажиллагаа явуулдаг баяжуулах үйлдвэрүүд байна.

АМТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "ашигт малтмал ашиглах" гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, **баяжуулах**, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг хэлнэ" гэж заасан боловч ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын баяжуулах үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр аж ахуйн нэгжүүдэд хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих боломжгүйгээс гадна хуульд заасан арга хэмжээг тооцох хуулийн зохицуулалт байхгүй байна.

Зөвхөн хайлуур жоншны флотацийн баяжмалын 2020 оны экспортыг судалж үзэхэд гарал үүсэл нь тодорхойгүй байдлыг харж болно.

Хүснэгт 5. Гарал үүсэл нь тодорхойгүй хайлуур жоншны экспорт

(ФФ 95-97 %)

№	Үзүүлэлт	Компанийн тоо	Үйлдвэрлэсэн хэмжээ	Экспортолсон хэмжээ	Эзлэх хувь
№ 1	Төлөвлөгөөт үйлдвэрийн дүн	11	115,177.13	115,177.13	81 %
2	Гарал үүсэл нь тодорхойгүй	50		26,218.90	19 %
3	Нийт бүтээгдэхүүний дүн	61		141,396.03	100 %

Хүснэгт 6. Гарал үүсэл нь тодорхойгүй хайлуур жоншны экспорт⁵

(ФФ 95-97 %)

№	Үзүүлэлт	Компанийн тоо	Үйлдвэрлэсэн хэмжээ	Экспортолсон хэмжээ	Эзлэх хувь
1	Төлөвлөгөөт үйлдвэрийн дүн	10	28,303.79	28,303.79	19 %
2	Гарал үүсэл нь тодорхойгүй	51		122,677.16	81 %
3	Нийт бүтээгдэхүүний дүн	61		150,980.95	100 %

2015-2020 оны хооронд хайлуур жоншны бүтээгдэхүүнээс АМНАТ-ийн хэлбэрээр улсын төсөвт 103.1 тэрбум төгрөг төвлөрөх байснаас 21.8 тэрбум төгрөг буюу 21 хувь нь төвлөрчээ. Гарал үүсэл нь тодорхойгүй экспортолсон ашигт малтмалаас АМНАТ төлөгдөөгүй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч уурхай нь нөөцгүй, зөвшөөрөл эзэмшигч бүтээгдэхүүн бусдаас худалдаж аваад тэрийгээ шууд экспортолдог.

Тэгээд эндээс нэг төгрөгийн татвар хураамж төлөхгүй, ердөө Икс тайлан гаргаад л, яваад байдаг ААН цөөнгүй бий.

Шигтгээ 1. (Салбарын төлөөлөл - ярилцлага)

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний

⁵ Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газрын мэдээ

мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан газрын хэвлийн нөхөн сэргээгдэхгүй баялгийн төлбөрийг бүрэн авч чадахгүй байна.

Иймээс АМТХ-ийн 5 дугаар зүйлийн “Ашигт малтмалын өмчлөл” буюу 5.1.-д *Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн*” гэсэн заалтыг тодорхой болгож бүх татвар, АМНАТ төлсний дараа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлд шилжих, баяжуулах, экспортлох үйл ажиллагаанд тавих хяналтыг төрийн байгууллагуудын зүгээс харилцан мэдээлэл солилцож, уялдаж ажиллах практик хэрэгцээ шаардлага байна.

Хууль бусаар ашигт малтмал олборлох тухай

Хууль бусаар ашигт малтмалыг гар аргаар олборлох үйл ажиллагаанд олон зуун хүн хамрагддаг, улирлын шинж чанартай анх эхэлж байсан бол сүүлдээ жилийн турш ажиллагаатай, амьжиргааны хэлбэр болон өргөжсөн. Энэ үзэгдэл нь улс төр, эдийн засаг, нийгмийн шилжилтийн үеийн ажилгүйдэл, мөнгөний ханш уналт, хүн амын бодит орлого буурах зэрэг эдийн засгийн бүтцийн сөрөг өөрчлөлтийн үр дагаврын хариуд гарч ирсэн. Хүмүүс эдгээр бэрхшээлийг даван туулах өөр өөрийн арга замыг олохдоо ихэнх тохиолдолд эдийн засгийн албан бус аргаар шийдвэрлэсэн байдаг.

Хууль, эрх зүйн болон зохицуулалтын хүрээнээс гадуур, эрсдэл бүхий, байгаль орчныг сүйтгэсэн, ажлын аюултай нөхцөл болон химийн хортой бодистой харьцаж байгаа зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны үлэмж сөрөг үр дагавар дагуулах болсон.

Олон улсын туршлагаас үзвэл ашигт малтмалыг хууль бусаар олборлох явдлыг зогсоох арга хэмжээний улс төрийн үнэ цэнэ, нийгэм, эдийн засагт гарах зардал нь өндөр байдаг байна. Гэхдээ байдлыг хяналтгүй орхих нь байгаль орчны болон нийгэм, улс төрийн эрсдэлийг бий болгодог. 2001 онд Засгийн газраас энэхүү албан бус үйл ажиллагааг зохицуулах түр хугацааны журам боловсруулан ашигт малтмалыг гар аргаар олборлох үйл ажиллагааг зохицуулах оролдлого хийсэн. Гэхдээ энэ журам нь үр дүнгүй, амьдралд хэрэгжих боломжгүй болох нь батлагдаж, жилийн дараа хүчингүй болгож, 2017 он хүртэл шинэчлэгдээгүй юм.

Монгол Улсад ойролцоогоор 100,000 гаруй албан бус, бичил уурхайчид 19 аймгийн нутаг дэвсгэрт албан бус олборлолт хийж байгаа нь хөдөө-орон нутгийн ажиллах хүчний 20 %-ийг эзэлж байгаа бөгөөд ихэнх нь алт олборлохын зэрэгцээ, мөн жонш, гянт болд, хагас үнэт чулуу, нүүрс бага хэмжээгээр олборлож байна.⁶

2010 онд Засгийн газар албан бус, бичил уурхайг албан ёсны ажил хөдөлмөр гэж хүлээн зөвшөөрсөн. Гэвч бичил уурхайчдын эрх нь албан бус олборлолт хийж буй газар нутгийн ойролцоох иргэдийн эрхтэй, ялангуяа байгаль орчны бохирдол, экологийн тэнцвэрт бус байдлын нөлөөлөлд өртөх (Үндсэн хуулийн 16.2-р зүйл) орон нутгийн иргэдийн эрхтэй байнга зөрчилддөг. Хөдөө-орон нутгийн ихэнх иргэдийн амьжиргаа (ажил хөдөлмөр, хоол хүнс) нь байгалийн нөөц баялгаас хараат байдаг тул, байгаль орчны доройтол нь уламжлалт амьжиргааг устгах эрсдэлтэй.

Бичил уурхайн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2010 оны 7 сарын 1-ний өдөр “Ашигт малтмалын тухай хууль”-д “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан.

Мөн 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичгийн 3.1.2.-д “бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;” тухай тусгасан байдаг. Дээрх эрх зүйн эх сурвалжийг үндэслэн Засгийн газрын 2017 оны 151

⁶ <http://www.asm-pace.org/blog/item/11-ninja-miners-and-rural-change-in-mongolia.html>

дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Гэсэн ч хамгийн багаар гар аргаар ашигт малтмал олборлогчдын дөнгөж 10 гаруй хувь нь хууль, журмын дагуу бүртгүүлж, үйл ажиллагаа эрхэлж байна. Өнгөрсөн онд хийгдсэн шалгалтаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан хэдий ч тухайн талбай дээрээ үйл ажиллагаа явуулдаггүй, талбайн хэмжээг хэтрүүлдэг, гэрээгээр халхавчлан өөр эрүүл талбай, нөхөн сэргээсэн талбай болон гэрээнд хамааралгүй газраас хууль бусаар олборлолт явуулсан, хүчин чадлын нөөцийг хэд дахин хэтрүүлсэн, сум орон нутгаас гэрээ байгуулахдаа тухайн байршлын солбицол, цэгийг газар дээр нь тулгаж шалгадаггүй, тухайн газар нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход тохирох эсэхийг шалгалгүйгээр эрүүл газар, эвдэгдсэн газарт хавтгайруулан гэрээ байгуулсан зэрэг зөрчлүүд илэрч байжээ.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлд “Монгол Улсын газрын хэвлий нь улсын хамгаалалтад байна” хэмээн хуульчилсан бөгөөд “Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага”-ыг хангасан байхыг тусгасан байна. Үүнд:

- 1/ газрын хэвлийн геологийн судалгааг иж бүрэн гүйцэд хийх;*
- 2/ газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх, түүнийг дур мэдэн ашиглах явдлыг гаргуулахгүй байх;*
- 3/ үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийг зөв зохистой, иж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах;*
- 4/ ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсэж болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах;*
- 5/ ашигт малтмалын ордыг усанд автах, үер, гал түймрээс болон ашигт малтмалын чанар, ордын үйлдвэрийн үнэт чанарыг бууруулах буюу түүний ашиглалтыг хүндрүүлж болох бусад хүчин зүйлээс сэргийлэн хамгаалах;*
- 6/ ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барих, уг талбайг ашиглах талаар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх;*
- 7/ ашиглаж байгаа болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооног, түүнчлэн газар доорх барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг газрын хэвлий ашиглах явцад үүсэж болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хамгаалах.*
- 8/ газар доор нефть, хий, материалыг хадгалах, хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах үед газрын хэвлий бохиртохоос сэргийлэх.*

“Газрын хэвлийн тухай” хууль батлагдсанаас хойш буюу өнгөрсөн 34 жилийн хугацаанд газрын хэвлийг ашиглах, хамгаалах зорилтын хэрэгжилт, үр дагаврыг үнэлж үзэхэд, олон эерэг үр дүнгийн зэрэгцээ цөөнгүй сөрөг үзэгдэл буюу газрын хэвлийн баялгийн хариу төлбөр болох АМНАТ-ийг бүрэн ноогдуулах, хууль бусаар ашигт малтмал олборлох үзэгдлийг таслан зогсоож, хяналт тавих зэрэг асуудал оршсоор байна.

2.2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт

“Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд **Газрын хэвлийн тухай” хуулийн 9 дүгээр зүйл** буюу “Газрын хэвлийг ашиглагч” болон 20 дугаар зүйл буюу “Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг”-тэй холбогдох асуудлыг тус тус судлахаар сонгосон болно. Иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

9 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглагч

1. Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглаж болно.
2. Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.

20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг

1. Ашиглагч нь газрын хэвлийг олгосон зориулалтын дагуу ашиглах үүрэг, эрхтэй.
2. Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:

“Газрын хэвлийн тухай” хуулийн 9.1, 9.2-р хэсэгт “Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гадна, гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно” гэж заасан нь тухайн харилцаанд оролцогч буюу субъектэд тавих хэлбэрийн болон агуулгын шалгуур хангалтгүй тусгагдсан байдаг.

“Газрын хэвлийн тухай” хуулийн энэхүү ноцтой дутагдлыг 1994, 1997, 2006 оны оны Ашигт малтмалын тухай хуульд давтсан бөгөөд сөрөг үг дагавар бүхий хийдэл байсныг Монгол улсын өнгөрсөн түүх, туршлага баталж байна.

1997, 2006 оны АМтХ-д тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага хангалтгүй байсны сөрөг үр дагавар нь ашигт малтмал хайх, ашиглах харилцаанд олон хэлбэрээр илэрсэн байдаг. Тухайлбал:

- 2006 оны АМтХ-ийн 7.1-д “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад **татвар төлөгч хуулийн этгээдэд**...олгоно” гэж зааснаас үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн дагуу байгуулагдан, татварын хуулийн дагуу Монгол Улсад татвар төлөгч аливаа хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүсэх эрхтэй байна.

- “Газрын хэвлийн тухай” хуулиар Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болохоор зааснаас гадна, газрын хэвлийг хугацаатай болон хугацаагүйгээр ашиглалтад олгож болохоор заасан бол “Ашигт малтмалын тухай” хуулиар ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсад үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд олгохоор заасан, ашиглалтын тусгай зөвшөөрөл нь зайлшгүй хугацаатай байх зэргээс өөр газрын хэвлий ашиглагчид тусгайлсан хуулийн шаардлага, нөхцөлийг сайжруулсан зүйл, заалт тусгагдаагүй.

- Монгол Улсад татвар төлөгч байх гэсэн хэлбэрийн шаардлага нь тусгай зөвшөөрөл хүсэгчийн хувьд эрх олгож байгаа зохицуулалт боловч нөгөө талаасаа нийгэм, эдийн засаг, эрх зүйн хүрээнд сөрөг үр дагавар үүсэх шалтгаан болсон байна. Учир нь 2004 он гэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо 7 мянга давсан бөгөөд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 47 хувийг хамарч, хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, уул уурхайн улмаас эвдэгдсэн, нөхөн сэргээлт хийх эзэн холбогдогчгүй талбайн хэмжээ үлэмж өсөж, гол мөрний сав газар дагасан олборлолт хяналтаас гарч байсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд зөвхөн тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тусгасан байдаг. Үүнээс шалтгаалан уул уурхайн салбарт мэргэжлийн боловсон хүчин байхгүй, санхүү эдийн засгийн чадавхгүй аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл авч, улмаар тусгай зөвшөөрлийг туслан гүйцэтгээгч нэрээр бусдад түрээслүүлдэг, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх

үүргээ хэрэгжүүлдэггүй, тусгай зөвшөөрлийг мөнгө олох арга хэрэгсэл болгон ашиглаж, уул уурхайн салбарын нэр хүндийг унагаж байгаа тул тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлагыг хуульд тусгаж, тусгай зөвшөөрөл олгоход тавих хуулийн шаардлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ 1. (Салбарын төлөөлөл - ярилцлага)

Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэгдсэн газрын өнөөгийн нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийх зорилгоор ашигт малтмал ашигласны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээлгүй орхигдсон газрын тооллого хийх ажлыг 2017-2018 онд зохион байгуулахаар Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны А/71 тоот тушаалаар уг тооллогыг хийх удирдамж батлагдсан. Тус тооллогоор 21 аймаг, 1100 нэгж талбарын, 27405,46 га-аас нөхөн сэргээх шаардлагатай орхигдсон газар 8871,18 га газар байна гэсэн дүн гарсан байна. (Хүснэгт 9)

Хүснэгт 8. Эвдэрсэн газрын тооллогын ажил 2012, 2018. БОАЖЯ

№	Аймаг	2012 онд		2018 онд Нийт эвдэрсэн газрын тоо /га/	Нөхөн сэргээх шаардлагатай орхигдсон	
		Нэгж талбар	Хэмжээ /га/		байршлын тоо	талбай /га/
1	Архангай	2	103.4	1084	11	5.5
2	Баянхонгор	237	708.91	377.34	41	126.7
3	Баян-Өлгий	6	45.2	43.32	9	41.42
4	Булган	4	19.7	1399	28	
5	Говьсүмбэр	1	10.2	75.2	10	9
6	Говь-Алтай	41	305.8	415.28	162	301
7	Дархан-уул	6	488.7	1010	151	531.6
8	Дорнод	6	32.6	1068	36	424
9	Дорноговь	112	41.37	20.48	81	20.48
10	Дундговь	20	172.98	562	200	41
11	Сүхбаатар	5	6.5	835	38	61.8
12	Сэлэнгэ	40	1181.42	3614.5	87	1184.4
13	Завхан	1	0.5	192		20.2
14	Орхон			47.8	37	36.88
15	Өвөрхангай	49	76.32	950	20	150
16	Өмнөговь	49	76.32	184	11	154
17	Хэнтий	47	402.18	5300	13	340
18	Ховд	10	193.6	199.98	12	84.6
19	Хөвсгөл	14	80	53.9	9	10
20	Төв/2016/	12	25.75	9088.1	112	4880.3
21	Увс	41	349.1	389.4	26	389.4
22	Нийслэл			496.16	6	58.9
	Нийт	703	4320.55	27405.46	1100	8871.18



урьдчилсан байдлаар
2017 онд хийж дуусгасан

2017 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн судалгаанд дурдсанаар уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр улсын хэмжээнд 10084.29 га талбай сүйтгэгджээ. Үүнээс техникийн нөхөн сэргээлтийг 2600 орчим га талбайд хийсэн бол ердөө 53 га талбайд л биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. БОАЖЯ-наас нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хөрөнгийг нийт 188 тэрбум төгрөг гэж тооцсон байна.

2019 оны эцсийн байдлаар 1,100 байршилд 27,405 га газар эвдэрснээс 8.8 мянган га газар буюу уул, ус, мод хамрах газар эзэн холбогдогч нь олдохгүй байгаа бөгөөд нөхөн сэргээхэд эхний ээлжид 540 тэрбум төгрөг шаардагдах тооцоог БОАЖЯ хийжээ. 2020 оны байдлаар нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 17 тэрбум төгрөгийг байршуулсан байгаа нь нийт шаардагдах хөрөнгийн 3 хувьтай тэнцэж байна.⁷

Газрын хэвлийн баялаг ашиглагчид хуулиар “зохих мэргэжлийн, санхүү, техник, технологийн шаардлага, шалгуур” тавигдаагүй тохиолдолд уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт-хаалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх, цаг тухайдаа ашигт малтмалын нөөцийн төлбөр, бусад татвараа төлөх үүргүүд бүрэн биелэх боломж бүрдэхгүй байсаар иржээ.

4 дүгээр зүйл. Газрын хэвлий, түүний улсын нэгдмэл сан

1. Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1-т “Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ”, 3-р зүйлд “...Газрын хэвлий нь төрийн өмч” гэж зааснаас тус тус үзэхэд газрын хэвлийд байгаа барилга байгууламж төрийн өмч байхаар ойлгогдож байна. Энэ нь “Үндсэн хууль”-ийн 5.2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалттай, 16.3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэсэн заалттай тус тус зөрчилдөж байна. Мөн газрын хэвлийд байгаа барилга байгууламж барих, тухайлбал газрын хэвлийд туннель, гараж барих зэрэг нийгмийн хөгжлийн зайлшгүй шаардлагаар бий болж буй хэрэгцээг зохицуулахад хүндрэл учруулж байна.

Газрын хэвлийн баялаг ашиглагчид тавих ерөнхий шаардлагыг шалгуур үзүүлэлтийн “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” үзүүлэлтээр дүгнэхэд хангахгүй байна.

Байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын түүх, ААН-ийн эцсийн эзэмшигчийн мэдээлэл зэрэг шалгуурыг газрын хэвлийн баялаг ашиглагчид тавих нь тухайн харилцааг зохицуулах боломжит хувилбар байж болох юм.

⁷ <https://www.montsame.mn/mn/read/249804>

10 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах зориулалт

1. Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгоно:

1/ геологийн судалгаа хийх;

2/ ашигт малтмал олборлох;

3/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;

4/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах.

2. Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох

1. Геологийн судалгаа хийх /геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлыг судлан ордыг илрүүлж үнэлгээ өгөх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодруулах зэрэг/-эд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох асуудлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2. Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ.

13 дугаар зүйл. Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох

Уурхайн эдэлбэр олгосон тухай актыг үндэслэн ашигт малтмалыг олборлоход зориулан газрын хэвлийг олгоно.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйл заасан “Газрын хэвлийг ашиглах зориулалт” буюу тус хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар хуульчилсан байна:

1/ геологийн судалгаа хийх;

2/ ашигт малтмал олборлох;

3/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;

Хүснэгт 9. Газрын хэвлийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Газрын хэвлийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт			
“Газрын хэвлийн тухай” хуультай орнууд	Газрын хэвлий тухай хуулийн зэрэгцээ төрөлжсөн хуультай орнууд	Геологи, уул уурхай тухай хууль	Төрөлжсөн хуультай орнууд
ОХУ, Казакстан, Киргиз, Узбекистан, Украин, Армен, зэрэг пост-социалист улсууд	Монгол улс	Польш	Англи, Америк, Австрали, Канад, Герман зэрэг баруун европын орнууд болон БНХАУ

Өнөөдөр дээрх харилцааг хамтад нь “Газрын хэвлийн тухай хууль” нэрээр зохицуулж байгаа орнуудад ОХУ, Казакстан Киргиз, Узбекистан, Украин, Армен, зэрэг пост-социалист улсууд орно.

Хуучин социалист улс орнууд 1990 оноос хойш “Газрын хэвлийн тухай” хуулиа зах зээлийн эдийн засагт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэсээр байгаа билээ.

Харин либерал ардчилсан барууны орнуудад төрөлжсөн хуулийн зохицуулалт давамгайлдаг байна. (Хүснэгт 10)

Төрөлжсөн хуультай орнууд сонгодог төлөөлөл нь Их Британи бөгөөд тус улсад 1592 оноос эхлэн алт, мөнгөний орд шууд хааны өмчлөлд хамаардаг учир тусгай хуулиар, нүүрс - эрчим хүч болон металлургийн стратегийн ач холбогдлоос шалтгаан мөн тусгай хуулиар, бусад ашигт малтмал өмчийн бүртгэлийн тухай хууль, газрын тухай хуулиар гэх мэт тухайн ашигт малтмалын өмчийн эзэмшлийн хэлбэрээс хамааран өөр өөрөөр зохицуулсан байдаг бөгөөд нийтийн эзэмшлийн бус, хувийн өмчлөлийн газар, түүний хэвлий нь бүхэлдээ өмчлөгчийн захиран зарцуулах эрхэд хамаардаг тул “Fee Simple Estate” гэсэн тусгай өмчийн эрхийн зохицуулалт үйлчилдэг онцлогтой.⁸ Ашигт малтмал ашиглах, олборлох үйл ажиллагаанд төрөөс хяналт тавих эрх зүйн үндэслэлийг “Уул уурхайн тухай” 1957 оны хуулиар зохицуулж иржээ. Мөн Геологийн судалгааны тухай хуулийг 1845 онд баталж байжээ.

Дээрх орнуудын Геологийн тухай болон геологи, уул уурхайн тухай хуулиудын агуулгад дараад хэд хэдэн онцлог харилцааг зохицуулж байна.

Нэгд, газрын хэвлийн тойм судалгаа, эрэл, хайгуул болон ашигт малтмалын ашиглалтын үеийн хайгуулын судалгаанд тавигдах нийтлэг зарчим, шаардлагыг тодорхойлж, газрын хэвлийн судалгааны хугацаа, судалгааны зориулалтаар газрын хэвлийг олгох, газрын хэвлийн судалгааг төлөвлөх, гүйцэтгэлийн талаар мэдээлэх, тайлагнах, газрын хэвлийн судалгааны тоо бүртгэлийг хэрхэн гүйцэтгэх талаарх нийтлэг эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон байдаг.

Хоёрт, газрын хэвлий нь газрын хэвлийн судалгаа, ашиглалтад олгогдсон эсэхээс үл хамаарч бүхэлдээ газрын хэвлийн мэдээллийн нэгдмэл санд бүртгэгдэх бөгөөд ашигт малтмалын ордын нөөцийн балансын бүртгэл нь газрын хэвлийн нэгдмэл сангийн үндсэн хэсэг байх тухай тодорхойлсон байдаг.

Гуравт, газрын хэвлийн мэдээллийн сангийн мэдээллийг хэрхэн ашиглах, бусдад танилцуулах гэх мэт үйл ажиллагааг эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг буюу бүртгэл, тайлагнал, мэдээллийн сангийн үйл ажиллагааны нарийвчилсан журмыг тусгасан байдаг.

Дөрөвт, газрын хэвлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тус байгууллагын дэргэд ажиллах Геологийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон байдаг. Үүнээс гадна орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон Засаг захиргааны эрх хэмжээг тодорхойлсон байдаг.

Тавд, тухайн улсын хэмжээнд газрын хэвлийн нэгдсэн удирдлага, зохицуулалтыг гүйцэтгэх, газрын хэвлийн судалгаа, ашиглалтын зохистой байдлыг бүрдүүлэх, улс орны эрдэс баялгийн салбарын нөөц бололцоог гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад сурталчлах, олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын нэгдмэл тогтолцоог тодорхойлж, газрын хэвлийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллагын эрх зүйн байдал, чиг үүрэг, удирдлагын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогийн талаар тусгасан байна.

Монгол улс 1990 онд зах зээлд шилжсэнээр, эдийн засгийн либерал бодлого баримталж Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай гэх мэт төрөлжсөн хууль баталж, “Газрын хэвлийн тухай” хууль-ийн зохицуулалтыг нарийвчлан дэлгэрүүлэх

⁸ PRINCIPLES OF MINERAL OWNERSHIP IN THE CIVIL LAW AND COMMON LAW SYSTEMS

Author(s): NICHOLAS J. CAMPBELL

Source: Proceedings (American Bar Association. Section of International and Comparative Law), proceedings (American Bar Association. Section of International and Comparative Law) (AUGUST 28, 1956), pp. 37-43

оролдлого хийж ирсэн. Гэвч энэ хугацаанд “геологийн судалгааны тухай болон уул уурхайн олборлох, боловсруулах” мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг бүрэн зохицуулсан хууль батлагдсаны өдий хүрсэн байна. Тухайлбал, “Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна” гэсэн боловч зөвхөн тусгай зөвшөөрөл олгох харилцааг нарийвчлан дэлгэрүүлж зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, 1994, 1997, 2006 оны АМТХ-ын Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох процессын журамласан зохицуулалтын хавсарга шинжтэй, уул уурхай мөчлөг төрийн төв болон салбарын захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, засаглалыг тогтоох хууль эрх зүйн үндэслэл орхигдуулж ирсэн байдаг.

Дээрх дүгнэлтийг тодруулах зорилгоор газрын хэвлийн баялгийг ашиглах буюу уул уурхайн үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хуультай орнуудыг төлөөлүүлж, Австрали улсын Хойд Австрали мужийн Уул уурхайн менежментийн тухай хуулийн агуулгатай танилцъя.

Хүснэгт 10. Хойд Австрали мужийн уул уурхайн менежментийн тухай хууль

ХОЙД АВСТРАЛИ МУЖИЙН УУЛ УУРХАЙН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬ (MINING MANAGEMENT ACT)
Ерөнхий үндэслэл 1. Хуулийн нэр 2. Хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа 3. Хуулийн зорилго 4. Хуулийн нэр томьёо 5. Хуулийн үйлчлэх хүрээ 6. Хуульд нэмэлт өөрчлөл оруулах журам 7. Энэ хууль үйлчлэхгүй нөхцөл 8. Иргэний эрх зүйн журмаар шийдвэрлэх асуудал 8A. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам Удирдлага, Чадамж 9. Уул уурхайн салбарт-? ажил эрхлэгчийн удирдлага, хяналтын хариуцлага 10. Эзэмшигч нь өөрөө уул уурхайн удирдлагыг хариуцан эсвэл тийм үүрэг бүхий этгээдийг томилно 11. Удирдлагын чадамж ба тавих шаардлага Байгаль орчин хамгаалах тухай - Division 1. Байгаль орчныг хамгаалах үүрэг - Division 3. Байгаль орчныг хамгаалах үүрэгтэй холбогдсон зөрчил 26. Байгаль орчинд ноцтой хохирол учруулах түвшин 29. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч байгаль орчинд ноцтой нөлөөлсөн тохиолдлыг мэдээлэх үүрэг 30. Уул уурхайн байцаагч шалгалт явуулах 31. Уул уурхайн ажил эрхлэгч шалгалт явуулах 31A. Олон нийтэд мэдээлэх 32. Байгаль орчинд ноцтой нөлөөлөл үүссэн бүсэд нэвтрэх эрхийг хязгаарлах - Division 5. Хариуцлага 33. Олборлолтоос үүсэх хаягдлын зохицуулалт Уул уурхайн үйл ажиллагаа - Division 1. Уул уурхайн салбар хариуцсан Сайдын эрх мэдэл - Division 2. Уул уурхайн үйл ажиллагаатай холбогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэх - Division 3. Уул уурхайн удирдлагын төлөвлөгөө - Division 4. Санхүүгийн баталгаа, татварын асуудал 46. Уурхайн хаалтын гэрчилгээ Уурхайн нөхөн сэргээлтийн сан 46A. Сан байгуулах 46B. Сангийн зорилго 46C. Санд төлбөр төлөх 46D. Сангаас зарлага гаргах Part 7. Уул уурхайн байцаагч

59. Уул уурхайн байцаагчийг томилох
 60. Уул уурхайн байцаагчийн үнэмлэх
 61. Уул уурхайн байцаагчийн чиг үүрэг
 62. Уул уурхайн байцаагчийн эрх мэдэл
 63. Уул уурхайн байцаагч уул уурхайн үйл ажиллагаатай холбогдон гомдол гаргасан этгээдийн нэрийг нууцлах үүрэгтэй
 64. Албаны үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага
 64А. Уул уурхайн байцаагчийн нэрийг хуурамчаар ашигласан этгээдэд хүлээлгэх хариуцлага
Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хариуцлага
 Division 1. Зөрчил, Хариуцлага
 Division 2. Эрүүгийн хэрэг үүсгэх
 Division 1. Сайд эрх мэдлээ хэрэгжүүлэх болон төлөөний этгээдийг томилох
 81. Сайд болон Ерөнхий байцаагчийн төлөөлөгч
 82. Байгаль орчныг хамгаалах
 82А. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс нутагт нийгэм, эдийн засгийн чиглэлд хамтран ажиллах
 83. Сайд уурхайн эдэлбэрт тусгай дэглэм тогтоох
 98. Байгаль орчинд учруулсан ноцтой нөлөөллийг мөрдөн шалгах, мэдээлэх

Хойд Австрали мужийн Уул уурхайн менежментийн тухай хуулийн гол цөм нь байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлт, хаалтын сангийн зохицуулалт, уул уурхайн засаглалыг бодлогын болон хэрэгжилтийн түвшний гүйцэтгэгч байцаагчийн чиг үүрэг, мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг тодорхой тусгасанд оршдог. Хойд Австрали мужийн Уул уурхайн менежментийн тухай хуулийн агуулгыг судлахад дараах онцлогтой байна. Үүнд:

- Уул уурхайн тухай эдгээр хуулиуд нь Уул уурхайн мэргэжлийн хяналтыг гүйцэтгэх албаны чиг үүрэг, байцаагчийн эрх үүрэг, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг тогтоох;
- Байгаль орчныг хамгаалах, Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиг үүрэг субъект, түүний эрх, үүргийг тодорхойлох;
- Уул уурхайн үйл ажиллагаанд “эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал”-ыг хангах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- Уул уурхайн нөхөн сэргээлт, хаалт, хаалтын сангийн баталгаатай холбоотой асуудлыг зохицуулах гэсэн үндсэн 4-н зорилготой байна.

Монгол улсын “Газрын хэвлийн тухай” хуульд уул уурхайн засаглалыг гүйцэтгэх хэрэгжилтийн түвшний гүйцэтгэгч нэгж болон байцаагчийн чиг үүргийг орхигдуулсныг эс тооцвол геологийн судалгааны тухай болон уул уурхайн олборлох, боловсруулах” мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад баримтлах зарчмууд тусгагдан байдгийг дурдах нь зүйтэй юм. Гол нь дээрх холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан, төрөлжсөн хуулиар зохицуулалгүй өдий хүрсэнд ноцтой дутагдал оршиж байна.

Тодорхой хэлбэл, хууль болон логикийн шинжлэх ухааны “Ерөнхий-Тусгай” зарчим алдагдсан бөгөөд ерөнхий органик хууль нь төрөлжсөн хуулиасаа илүү нарийн зохицуулалт агуулж байхад, төрөлжсөн хууль дэлгэрүүлсэн заалт дутмаг байгаа нь “Газрын хэвлийн тухай” хуулийг “тунхгийн” шинжтэй болгосон байна.

Тодорхой хэлбэл, “Газрын хэвлий” гэдэг нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ” гэж заасан байна.

“Газрын хэвлийг ашиглах” гэдэг нь “Газрын хэвлийн тухай” хуульд зааснаар геологийн судалгаа хийх /”Газрын хэвлийн тухай” хуулийн 12 дугаар зүйл/, ашигт малтмал олборлох /”Газрын хэвлийн тухай” хуулийн 13 дугаар зүйл/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах зориулалтаар /”Газрын хэвлийн тухай” хуулийн 15 дугаар зүйл/ ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг хэлэх бөгөөд ашигт малтмал хайх, ашиглах, олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахаар хуульчилжээ.

2.3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 12, 6, 10, 15, 51, 52, 53 дугаар зүйлтэй холбогдох асуудлыг судлахаар сонгосон. Тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох

1. Геологийн судалгаа хийх /геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлыг судлан ордыг илрүүлж үнэлгээ өгөх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодруулах зэрэг/-эд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох асуудлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2. Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сүм, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ.

Монгол Улсын геологийн салбарын эрх зүйн орчны хөгжил 1990 оноос хойш үндсэндээ зогсонги байдалд орж, геологийн судалгаатай холбоотой харилцаа тодорхой төрлийн ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын хүрээнд салбар, тусгай хуулиудаар зохицуулах чиг хандлага давамгайлж суурь хууль болох “Газрын хэвлийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо суларсан.

Тухайлбал, 2006 оноос хойш улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны төлөвлөсөн болон гүйцэтгэлийг Хүснэгт 12-оос харна уу.

Хүснэгт 11. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил

Он	Төлөвлөсөн (сая ₮)	Гүйцэтгэл (сая ₮)
2006	1,671.1	1,360.6
2007	2,532.4	2,149.1
2008	3,481.5	2,242.2
2009	2,425.2	1,990.3
2010	4,055.5	3,724.4
2011	4,000.0	3,927.7
2012	3,999.9	3,995.0
2013	7,326.1	6,756.0
2014	10,000.0	7,464.3
2015	11,341.1	6,467.8
2016	9,341.3	9,341.1
2017	13,335.9	12,555.1
2018	13,335.9	10,263.0
2019	24,621.9	23,751.7
2020	24,621.9	24,621.7
2021	27,430.0	24,271.8




График 1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил

Тодруулбал, 1992 онд Газрын тосны тухай хууль, 1994 онд Ашигт малтмалын тухай хууль, 1995 онд Усны тухай хууль гэх мэт салбар хуулиудыг батлахдаа “Газрын хэвлийн тухай” хуульд газрын хэвлий дэх геологийн судалгааны асуудлыг цогцоор нь геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулах, газрын хэвлийн судалгаа, удирдлага нэгдмэл байх зарчмыг зөрчин “Газрын хэвлийн тухай” хуульд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулалгүй орхигдуулж байсан нь төрөөс геологийн салбарт баримтлах бодлогын эрх зүйн орчны цогц байдлыг алдагдуулж ирсэн.

Тухайлбал, “Газрын хэвлийн тухай” хуулийг дагаж мөрдөж ирсэн 30 орчим жилийн хугацаанд газрын хэвлийн судалгаа, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, үр дүн, тайлан, мэдээ мэдээллийн санг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар бүрдүүлэн хөтлөх ажил өрөөсгөл түвшинд явж ирсэн нь эрх зүйн болон төрийн байгууллагын хоорондын уялдаа, нэгдмэл байдал алдагдаж ирсэн буюу газрын хэвлийн талаар төрийн нэгдсэн төлөвлөлт, бодлого, судалгааны институт байхгүй байсантай холбоотой юм.

Энэ байдлаас үүдэн газрын хэвлийг судлах, урт хугацааны нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд ашиглах боломж, газрын хэвлийн ашигт чанарыг, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлага, улс болон орон нутгийн хөгжил, газар төлөвлөлт, дэд бүтэц, хот байгуулалтын бодлого, үйл ажиллагааны харилцан уялдаа суларсан байна гэж үзэж болох юм.

“Газрын хэвлийн тухай” хуулиар геологийн судалгаа хийхийг газрын хэвлийг ашиглах ойлголтод хамруулж байгааг нь Ашигт малтмалын тухай хуулиар болон бусад салбар хуулиар тодорхойлсон “ашиглах” ойлголт адилтгах төөрөгдөл үүсгэж ирсэн байдаг. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад эрлийн эрхийг үндсэндээ хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгож байгаа бөгөөд Ашигт малтмалын тухай хуулиар эрэл болон хайгуулын ажлыг тус тусад нь ялгавартайгаар тодорхойлсон хэр нь тэдгээрийг гүйцэтгэх эрхийг хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгохоор зохицуулсан нь олон улсын жишгээс хазайсан, үндсэндээ эрлийн үйл ажиллагааны онцлог, ач

холбогдлыг бууруулсан буюу эрлийн шатанд гүйцэтгэх төрийн зохицуулалт, дэмжих чиг хандлага, оролцоог орхигдуулсан, томоохон талбайг хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд удаан хугацаанд тодорхой аж ахуйн нэгж хүлээн аваад бүрэн дүүрэн эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэлгүйгээр дарах, тухайн талбайн тодорхой хэсэгт гүйцэтгэсэн ажлын зардлыг хувь тэнцүүлэн бусад талбайд эрэл, хайгуулын ажил гүйцэтгэсэн мэтээр тайлагнах буюу газрын хэвлийн судалгааны ажлын үр өгөөж, эргэлтийг бууруулж ирсэн байж болохоор байна

Иймд газрын хэвлийн эрлийн шатны зохицуулалтыг хайгуулаас тусад нь нарийвчлан тодорхойлох шаардлага бий.

Мөн газрын хэвлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг буюу олон улсын жишгээр “Үндэсний геологийн алба”-ыг байгуулах талаар өнгөрсөн хугацаанд маш олон бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төлөвлөгөө, Ашигт малтмалын тухай хуульд зорилт, зүйл заалтууд тусгаж ирсэн ч эрх зүйн орчныг нь шаардлагатай хэмжээнд тодорхойлж чадаагүй. Энэ бүхэн нь шууд бусаар газрын хэвлийн төрийн бодлого зохицуулалтыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар тодорхойлох, хэрэгжилтийг хангахад бэрхшээл учруулсаар ирсэн байна.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудын хүрээнд геологийн салбарын хүрээнд дараах хэрэгжилтийн үр дагавар байна. Үүнд:

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1 дэх хэсэгт “тойм судалгаа”, “ашигт малтмал эрэх” болон “ашигт малтмал хайх” гэсэн нэр томъёог тодорхойлохдоо “геологийн судалгаа хийх”-ийг ойлгоно гэх агуулгаар тодорхойлсон байгаа болон “Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2 дах хэсэгт “ашигт малтмал хайх харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна” гэж хэсэгчлэн зохицуулахаар заасны агуулга холбоо ойлгомжгүй байна.

Хэрэв, “геологийн судалгаа” гэх ойлголт нь тойм судалгаа, зураглал-эрэл, эрэл-хайгуулын шатыг хамаарч байгаа бол Газрын хэвлийн хуулиар “геологийн судалгаа” гэх нийтлэг нэр томъёогоор ашигт малтмал хайхтай холбоотой харилцааг давхардуулан зохицуулсан болж таарч байна. Үүнээс гадна, “тойм судалгаа” болон “эрэл”-ийн шатанд газрын хэвлийг буюу газрын хөрснөөс дооших орон зайд өрөмдлөг хийдэггүй, хөрснөөс дооших орон зайг хөндөхгүй гэх ойлголтыг хуулиудад заасан байх боловч зарим хуульд буюу тухайлбал, Газрын тосны тухай хуулийн 15.4 дэх хэсэгт тухайлан уламжлалт бус газрын тосны эрлийн үед өрөмдлөг хийж болохоор заасан нь эрх зүйн орчны эрх тэгш, нэг ойлголтыг нийтлэг байдлаар мөрдөх зарчмуудтай зөрчилдөж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 11¹.1.3 дах заалтыг агуулгын хувьд Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.2.2.6-т заасан “Монгол Улсад гүйцэтгэж байгаа төрөл бүрийн геологийн судалгаа /байгалийн рашаан, гидрогеологийн судалгаа, байгалийн хий, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, инженер геологи гэх мэт/-ны мэдээлэл, нөөц, үр дүнгийн тайланг үндэсний гео-мэдээллийн нэгдсэн санд хамруулж улсын бүртгэлд авах” зорилттой шууд холбоотой боловч мэдээллийн сангийн нэршлийн зөрүү гэх мэт асуудлуудаас үүдэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх геологийн нэгдсэн санг бүрдүүлж чадахааргүй байна.

Тодруулбал, нэгдсэн санд хамаарах “геологийн мэдээллийн сан”, “уул уурхайн мэдээллийн сан” болон “нөөц баялгийн мэдээллийн сан” –уудад ямар мэдээллүүд хамаарах, тэдгээр нь хаана хаана хадгалагдаж байгаа, төрийн ямар ямар байгууллагаас мэдээлэл төвлөрүүлэх эсэх асуудал тодорхойгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 11¹.1.3-т УГА хэрэгжүүлэхээр заасан дээрх чиг үүрэг нь агуулгын хувьд мөн хуулийн 11.1.5 дах заалтаар АМГТГ нь “үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах” гэсэн чиг үүрэгтэй давхардсан байна.

ҮГА-ны чиг үүрэгт ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд Ашигт малтмалын тухай хуулиар АМГТГ-ын зүгээс тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэлийг хөтлөхөөр заасан бөгөөд уг бүртгэл ҮГА-ны зүгээс хөтлөх ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлтэй хэрхэн уялдуулах, бүртгэлийн нэгдсэн байдлыг хэрхэн хангах талаар нягтлах шаардлагатай болж байна.

Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын багцад туссан улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх геологи судалгааны ажлуудыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль журмын хүрээнд зөвхөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохицуулж байна. Гэвч энэ зохицуулалт нь улсын хэмжээний геологийн нэгдсэн сан, нөөцийн нэгдсэн бүртгэл гэх мэт өндөр ач холбогдол бүхий төрийн нууцын горимоор хамгаалагдвал зохих ажлуудыг аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагыг үүсгэж, энэ нь цаашлаад тэдгээр мэдээллийн өмчлөл нь уг аж ахуйн нэгжийн бусдад төлөх өр, төлбөр, барьцааны зүйлд ашиглагдах буюу бусдад шилжих боломжийг нээж байна.

Мэдээлэл технологийн эрин үед улс үндэстнүүд өөрийн улсын геологийн мэдээллийн анхдагч өгөгдлийг үндэсний нэг чухал нөөц сурвалж гэж үзэж, түүний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр тусгайлан бодлого хэрэгжүүлж байна. Геологийн анхдагч мэдээллийг ашиглан түүнд дүн шинжилгээ хийж улс төр, бизнес, хөрөнгө оруулалтын чиглэлд ухаалгаар ашиглаж байна.

Шийдвэрлэх шаардлагатай асуудлууд :

1. “Газрын хэвлийн тухай” хууль болон Ашигт малтмалын тухай болон бусад салбар хуулиудын хүрээнд “геологийн судалгаа” гэх үндсэн нэр томъёоны тодорхойлолт, геологийн судалгааны хамрах хүрээг тодорхой болгож, хуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах;
2. Газрын хэвлийд хамаарах олон тооны мэдээллийн сан, бүртгэлийн зохицуулалтыг тодорхой болгож Ашигт малтмалын тухай хуулийн 11¹.1.3-д заасан Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд төвлөрүүлэх асуудлыг холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;
3. ҮГА-ны Геологийн баримтын төв архив, Гео-мэдээллийн төвд төрөлжсөн хэлбэрээр хадгалагдаж буй мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, улсын хэмжээний геологийн нэгдсэн сан, нөөцийн нэгдсэн бүртгэл гэх мэт хамгаалбал зохих мэдээллийг хууль бусаар, нийтэд задрах эрсдэлээс сэргийлэх үүднээс зарим шаардлагатай төслүүдийг ҮГА өөрөө гүйцэтгэх эрх зүйн боломжийг нээж өгөх;
4. Газрын хэвлийн бүхий л төрлийн геологийн судалгааны ажлын удирдлага, зохицуулалтыг нэгдсэн нэг байгууллагад төвлөрүүлэх, ялангуяа, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авах нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээрх бодлогын хэрэгжилтийг хангах, улс орны тогтвортой хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэхтэй шууд холбоотой тул ҮГА-ны бүтэц, түүний удирдлага, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг Сангийн яамнаас бодлогын хүрээнд дэмжих;
5. Геологийн төв лаборатори ТӨҮҮГ, Геологийн судалгааны төв ТӨҮҮГ-уудыг ҮГА-ны харьяанд ажиллуулах асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

6 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах

3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3/ газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;

4/ ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгох;

5/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд төрийн хяналт тавих;

Үндсэн хуулийн 16.2-т Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан боловч уул уурхайн салбараас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэссэнтэй холбогдуулан “байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах” зарчмыг онцгойлон заасан.

Хариуцлагагүй уул уурхайн уршгаар одоо болон ирээдүй үеийн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах” үндсэн эрх зөрчигдөхөд хүрсэн. Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил нь эдийн засагт ихээхэн үр өгөөжтэй хэдий ч байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа тул онцгойлон анхаарах шаардлага тулгарч байгааг ХЭҮК тэмдэглэсэн байдаг.

НҮБ-ийн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны тайланд Монгол Улсад уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин хамгаалах хууль зүйн орчин хангалтгүй байгаа бөгөөд уг үйл ажиллагаанаас малчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрх, түүний дотор бэлчээр, малын тэжээл бэлтгэдэг газар нутаг, усны нөөцөд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар цохон тэмдэглэсэн байна.⁹

Уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчинтой холбогдох үндэслэл нь:¹⁰

- Олборлож буй металл болон аж үйлдвэрийн ашигт малтмал нь байгаль орчныг бохирдуулагч болдог тул;
- Үйлдвэрлэлийн явцад ашигтай эрдсүүдийг ялган авахын зэрэгцээ дагалдах бусад эрдэс, хүнцэл зэргийг ялган авахгүй бол байгаль орчныг бохирдуулагч болдог тул;
- Уул уурхайн бусад үйл ажиллагаанд хэрэглэж буй шатахуун, химийн бодисууд байгаль орчныг бохирдуулагч болдог тул;
- Уул уурхайн салбарт болгоомжтой хандаж, зөв харилцаж, хэрэглэхгүй бол байгаль орчин, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, удам зүй, улс орны хөгжилд эргээд нөлөөлж болзошгүй юм.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулахад байгалийн нөөц баялгийн эрх зүйн зохицуулалтаар газар, газрын хэвлий, ашигт малтмалыг ашиглах эрх, түүнийг хамгаалах үүргийг хуулиар хүлээн зөвшөөрсөн. Мөн бусад объект болох агаар, ус, ой, амьтан,

⁹ Committee on Economic, Social and Cultural Rights, "Concluding observations on the fourth periodic report of Mongolia," (2015) E/C.12/MNG/CO/4, 11

¹⁰ХЗҮХ, Эрдэс баялгийн эрх зүйн тойм ном, УБ., 2012 он, 161 дэх тал.

ургамлын төлөв байдлыг алдагдуулахгүйгээр, химийн хортой бодисын зөв хэрэглээг шаарддаг. Газрын хэвлийгээс ашигт малтмал олборлох бүх арга технологиуд нь биосферийн бүхий л элементүүд болох усны нөөц, агаар мандал, газар ба түүний хэвлий, ургамал, амьтны ертөнц зэргийг хөндөж, экологийн тэнцвэрт байдалд шууд ба дам байдлаар сөрөг нөлөө үзүүлж, ялангуяа газарт ихээхэн хэмжээний эвдрэл үүсгэдэг.¹¹

Иймээс уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, учирсан тохиолдолд сөрөг нөлөөллийг арилгах, нөхөн сэргээх байгаль орчныг хамгаалах багц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч энэхүү ойлголт Монгол Улсын уул уурхайн салбарын хувьд газрын эвдрэлийг нөхөн сэргээх гэсэн явцуу утгаар зохицуулагдаж байна.

2016 оны байдлаар 15 аймгийн 56 сумын нутаг дэвсгэрт 566 нэгж талбарт 3984.46 га газар уул уурхайн улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон байна. Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээхэд хамгийн багадаа 1 га талбайг 25.0 сая төгрөгөөр бүрэн нөхөн сэргээхэд 80-100 тэрбум төгрөгийн зардал шаардлагатай. 2016 оны байдлаар нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 10.5 тэрбум төгрөгийг байршуулсан байгаа нь нийт шаардагдах хөрөнгийн 10 хувьтай тэнцэж байжээ.

2017 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн судалгаанд дурдсанаар уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр улсын хэмжээнд 10084.29 га талбай өртсөн байна. Үүнээс техникийн нөхөн сэргээлтийг 2600 орчим га талбайд хийсэн бол ердөө 53 га талбайд л биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. БОАЖЯ-наас нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хөрөнгийг нийт 188 тэрбум төгрөг гэж тооцсон байна.

2019 оны эцсийн байдлаар 1,100 байршилд 27,405 га газар эвдэрснээс 8.8 мянган га газар буюу уул, ус, мод хамрах газар эзэн холбогдогч нь олдохгүй байгаа бөгөөд нөхөн сэргээхэд эхний ээлжид 540 тэрбум төгрөг шаардагдах тооцоог БОАЖЯ хийжээ.

Дээрх хугацаанд төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байгаа боловч эвдэрсэн, нөхөн сэргээх шаардлагатай талбайн хэмжээ буурахгүй байгаа нь хариуцлагатай уул уурхайн хөгжүүлэх үйл хэрэгт бэрхшээл учруулж байна.

Мөн уул уурхайн ажил нь өндөр эрсдэлтэй ажиллагаа байдаг тул аж ахуй нэгж дампуурсан тохиолдолд нөхөн сэргээлтийг хийлгэж чадахгүйд хүрнэ. Тиймээс анх тусгай зөвшөөрөл олгохдоо нөхөн сэргээлтийг даатгуулсан байх гэх мэт эрсдэлээс сэргийлсэн зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

Зураг 1. Эвдэрсэн газрын тооллого

¹¹Хамтын бүтээл, Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал, УБ., 2010 он, 30 дахь тал.

Эвдэрсэн газрын төрөл, хэмжээ (га)



Уул уухайн салбарын үйл ажиллагааны явцад байгалийн тэнцэл болон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд сөрөг нөлөө их гарч буй нь үүнийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх механизм сайн ажиллахгүй байгаатай холбоотой. Жишээлбэл, Эдийн засаг нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай манай улсын хувьд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ач холбогдол туйлын чухал боловч энэ үнэлгээний механизм ажиллахгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бүхий л уул уурхайн төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хянаж залруулга хийх чиг үүрэг бүхий 7 хүнтэй хэлтэс ажиллаж байгаа бөгөөд эндээс харахад, Монгол улсын уул уурхайн салбарын ач холбогдол болон энэ салбарын байгаль орчин болон хүний эрхийн асуудалд үзүүлдэг нөлөөллийн далайцыг бодолцон энэхүү чухал үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцөд нэн даруй хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь бусад өөр тайлангуудаас хуулбарласан шинжтэй, нэр төдий хийгддэг гэдгийг онцлохын зэрэгцээ өөр бусад дараах нийтлэг асуудлыг тодорхойлж шийдвэрлэхийг зөвлөжээ.


- байгаль орчны стандарт сайн боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв хэт бага, хүн нөөцийн дутагдалтай бөгөөд хэт их ачаалалтай;
- байгаль орчны аудит хараат бус, мэргэжлийн түвшинд хэрэгждэггүй бөгөөд байгаль орчны аудитад хяналт тавих үүрэг бүхий нэг л албан хаагч яаманд ажилладаг тул дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд арга хэмжээ авах, хариуцлага тооцох боломж муу;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зөөврийн шинжилгээний тоног төхөөрөмжгүй ба хангалттай тооны албан хаагч байхгүй;
- байгаль орчны эсрэг гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах нь ховор.

Эвдэрсэн газрын тооллогын ажил 2012, 2018

№	Аймаг	2012 онд		Нийт эвдэрсэн газрын тоо /га/	Нөхөн сэргээх шаардлагатай орхигдсон	
		Нэгж талбар	Хэмжээ /га/		байршлын тоо	талбай /га/
1	Архангай	2	103.4	1084	11	5.5
2	Баянхонгор	237	708.91	377.34	41	126.7
3	Баян-Өлгий	6	45.2	43.32	9	41.42
4	Булган	4	19.7	1399	28	
5	Говьсүмбэр	1	10.2	75.2	10	9
6	Говь-Алтай	41	305.8	415.28	162	301
7	Дархан-уул	6	488.7	1010	151	531.6
8	Дорнод	6	32.6	1068	36	424
9	Дорноговь	112	41.37	20.48	81	20.48
10	Дундговь	20	172.98	562	200	41
11	Сүхбаатар	5	6.5	835	38	61.8
12	Сэлэнгэ	40	1181.42	3614.5	87	1184.4
13	Завхан	1	0.5	192		20.2
14	Орхон			47.8	37	36.88
15	Өвөрхангай	49	76.32	950	20	150
16	Өмнөговь	49	76.32	184	11	154
17	Хэнтий	47	402.18	5300	13	340
18	Ховд	10	193.6	199.98	12	84.6
19	Хөвсгөл	14	80	53.9	9	10
20	Төв/2016/	12	25.75	9088.1	112	4880.3
21	Увс	41	349.1	389.4	26	389.4
22	Нийслэл			496.16	6	58.9
	Нийт	703	4320.55	27405.46	1100	8871.18

урьдчилсан байдлаар
 2017 онд хийж дуусгасан

График 2. Эвдэрсэн газрын тоо аймгаар



Хүснэгт 12. Хохирол учирсан талбай, үндсэн ангиллаар, улсын дүн, жилээр¹²

Төрөл	2017	2018	2019	2020
Хохирол учирсан нийт талбай	3,458.7	7,355.6	7,815.7	5,559.2
Тариалангийн газар	70.9	106.2	139.2	86.6
Бэлчээр ба бусад өвслөг ургамалт газар	3,140.9	7,000.0	7,030.2	5,255.6
Хот, тосгон, бусад суурины газар	11.6	21.5	49.9	44.2

¹²https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2400_009V1&CL_LAND_select_all=0&CL_LANDSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table

Ойн сан бүхий газар	225.5	209.3	570.8	136.6
Усны сан бүхий газар	6.1	0.2	1.8	0.2
Ухагдаж эвдэрсэн газар	3.7	18.3	23.9	36.1
Геологийн эрэл, хайгуулын ажлаас	0.2	0.7	0.0	8.1
Ашигт малтмалын олборлолтоос	3.1	16.0	23.3	27.1
Батлан хамгаалах, аюулгүй байдлын үйл ажиллагаанаас	0.2	0.1	0.1	0.0
Барилга, инженерийн шугам, сүлжээ барих, засвар үйлчилгээний ажлаас	0.2	0.1	0.2	0.0
Зам, тээвэр, холбооны барилга, засвар, үйлчилгээний улмаас	0.1	1.4	0.2	0.9

2003 онд мэргэжлийн хяналтын байгууллагыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж бүх яамдын хяналтын чиг үүргийг нэг байгууллагад буюу нэгдсэн тогтолцоонд шилжсэн боловч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хуучин хяналтын агентлагуудын ажлын арга барилыг үндсэнд нь хэвээр хадгалан, яамдын харьяанд байсан хяналтын газрууд шиг ажиллаж ирсэн байна.

Бүх хяналтын асуудал нэг байгууллагад төвлөрснөөр байгууллагын ажлын ачааллыг нэмэгдүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болгосон байна. Улмаар салбарын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын дотоод хяналт, хариуцлага суларч, аливаа гажуудлыг хариуцах эзэнгүй болсон байна. Мөн мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг бусад хяналтын байгууллагын чиг үүрэгтэй давхацсан, хүн амын аюулгүй байдалд төдийлөн ач холбогдолгүй, эрсдэлд

51 дүгээр зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд тавих төрийн хяналтын зорилт

1. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтын зорилт нь тус улсын яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, түүнчлэн гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүн хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журмыг сахиж, түүнийг ашиглахад аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах, сэргийлэх, уг аюул, хортой нөлөөг арилгах үүргийн биелэлтийг хангах, ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэлийн журам, түүнчлэн газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн бусад заалтыг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино.

2. Газрын хэвлийн геологийн судалгаанд төрийн хяналтыг харьяалал харгалзахгүйгээр тавих бөгөөд түүний зорилт нь холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас геологийн зураглал, эрэл, хайгуул, гидрогеологи, инженер-геологи, геофизик, геохимийн болон газрын хэвлийн геологийн судалгааны бусад ажлыг зохих ёсоор үр ашигтай гүйцэтгүүлэхэд оршино.

52 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд хяналт тавих байгууллага

1. Геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд тус тус хяналт тавина.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Засаг дарга нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг нутаг дэвсгэртээ эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.

53 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх

суурилаагүй олон тооны, үр нөлөө багатай хяналт, шалгалт хийх, торгох, шийтгэх хандлагыг урьтал болгон өнгөц, хийсвэр байдлаар ажиллах болсон байна.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлд зааснаар УУХҮЯ нь газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд, БОАЖЯ нь газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд төрийн хяналт тавих бүрэн эрх хэрэгжүүлнэ. (Хавсралт 3)

Түүнчлэн тус хуулийн 52.2-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Засаг дарга нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг нутаг дэвсгэртээ эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ” гэж заажээ. Эдгээрээс үзвэл “Газрын хэвлийн тухай” хуульд “төрийн хяналт”-ыг холбогдох яамд, тухайн орон нутгийн ИТХ, ЗД хэрэгжүүлэхээр байгаа бол бусад хуулиудад МХЕГ хэрэгжүүлэхээр хуульчилсан нь зарим талаар зөрчилтэй байна.

Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь газрын хэвлий ашиглах, хамгаалах харилцаанд дараах хяналтыг тавьж ажиллана байна. Үүнд:

- “Газрын хэвлийг дур мэдэн ашиглах, Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн; Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн эсэх;
- Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсэх;
- Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн эсэх;
- Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн; Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсэж болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй; Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн” эсэх хамаарч байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудын хамтын ажиллагаа сул, зарим асуудалд хамтарч ажилладаггүй, боловсруулан гаргаж байгаа бодлогын баримт бичгүүдийн хоорондын харилцан уялдаа байхгүй шалтгааныг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 13. Төрийн байгууллагын чиг үүрэг, уялдаа

Д/д	Уул уурхайн үйл ажиллагаанд хамаарах асуудал	Зохицуулалт хариуцсан төрийн захиргааны байгууллага
1.	Ашигт малтмалын орд ашиглахтай холбогдох эдэлбэр газрын асуудал	Барилга хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
2.	Ашигт малтмалын олборлолтын дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх асуудал	Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

3.	Ашигт малтмал хайх, олборлох, баяжуулах асуудал	Уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
4.	Уул уурхайн төслийн ТЭЗҮ хийх мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох газар ашиглах	Барилга хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
5.	Уурхайн үйл ажиллагааны явцад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах	Мэргэжлийн хяналтын газар Орон нутгийн захиргаа

МХЕГ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахдаа дээрх төрийн захиргааны төв байгууллагуудын уялдаа, холбоогүй нөхцөл байдал, хүнд суртлаас шалтгаалсан асуудлуудыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн хариуцлага мэтээр ойлгож албан шаардлага ирүүлдэг гэх мэт үл нийцэх тогтолцоонууд байсаар байна. Дээрх төрийн захиргааны төв байгууллагуудын хамтын ажиллагаа сул, зарим асуудалд хамтарч ажилладаггүй, тэдний гаргаж байгаа бодлогын баримт бичгүүдийн хоорондын харилцан уялдаагүй байдал нь цаг хугацаатай уралдан хэрэгжүүлэх гэж байгаа эдийн засгийн өндөр үр ашигтай төслүүдийн явцыг удаашруулж, төрийн дарамтыг ихэсгэж төслийг гацаах асуудлууд ээлж дараалан гарсаар байна. Тухайлбал:

Нэгдүгээрт: АМГТГ, МХЕГ, БОАЖЯ-ны чиг үүргийн давхардал их, хоорондын харилцан уялдаатай, мэдээллээр түргэн шуурхай хангах асуудал дутагдалтай, нэгэнт чиг үүргийн давхардал байгаа тул хариуцлага хүлээх асуудал төвөгтэй, орон нутаг дахь АМГТГ-ын хяналт тавих нөөц бололцоо дутмаг зэрэг шалтгаанууд нь ашигт малтмалын үйл ажиллагаа хуулийн дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Хоёрдугаарт: “Газрын хэвлийн тухай” хуульд Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу УУХҮЯ хяналт тавихаар тусгасан байхад АМтХ-д энэхүү үйл ажиллагаанд АМГТГ хяналт тавихаар, УУХҮЯ зөвхөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихаар тусгасан нь хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй байна. Мөн “Газрын хэвлийн тухай” хуулиар УУХҮЯ нь ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт буюу газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгаа нь АМтХ-тай зөрчилдөж байна.

Гуравдугаарт: БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, аймаг, сумын Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцдоггүй, үйл ажиллагаанд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлдэггүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй байна. БОНБтХ-д зааснаар БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавихаар тусгасан байгаа нь хяналт тавих асуудлыг зохицуулсан сайн хэдий боловч үүрэг хариуцлагыг хэт ерөнхийлсөн, ямар чиг үүргийг аль байгууллага хариуцах нь тодорхойгүй дутагдалтай байна.

Дээр дурдсанаар төрийн байгууллагуудын чиг үүрэг давхардсанаас хуулийн хэрэгжилт, бодлого, хяналт нь орон нутгийн түвшинд нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байх үндэслэл болсон байна. Мөн хяналт тавих үүрэг бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, үл ойлголцох явдал гарсаар байна. Зарим аймгийн ИТХ, Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажилладаггүй болох нь аудитын тайлангуудад дурдагдсан байна.

Төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгахын тулд хяналтын тогтолцоог оновчтой болгох шаардлагатай байна.

Улсын төсвийн нэгээхэн хэсгийг бүрдүүлдэг чухал салбарын хувьд УУХҮЯ-ны бүтэц бүрэлдэхүүний асуудал, тэр дундаа орон нутагт салбар байгууллага ажиллуулах, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх гэм мэт асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Газрын хэвлийн баялаг ашиглах, хамгаалах харилцаанд орон нутаг буюу Засаг даргад хэт өргөн хүрээний чиг үүрэг олгосон нь тухайн салбарын мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэгтэй давхцах, Засаг даргын тамгын газрын зүгээс хяналт тавих ажилд мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас хэлбэрийн төдийн хандах байдал ажиглагдаж байна.


Практикт Засаг даргад төлөвлөгөө, тайлан хүргүүлэх, батлуулах харилцаатай холбоотой сөрөг үр дагавар цөөнгүй тохиолддог бөгөөд цаад шалтгаан нь субъектив шинжтэй, засаг дарга нь улс төрийн албан тушаал учраас асуудалд объектив ханддаггүй байдлаас үүдсэн үр дагавар нийтлэг байна.

Энэ бүхийг дүгнэхэд, 1990 онд зах зээл, ардчилалд шилжих үеэс газрын хэвлийн баялгийг ашиглах, хамгаалах харилцаанд хяналт тавих орон нутагт нэгжгүй байснаас, орон нутаг, бүсийн нэгжийн үүргийг засаг даргын тамгын газрын чиг үүрэгт хамааруулж хуульчилсан нь өнгөрсөн хугацаанд оновчтой зохицуулалт биш гэдэг нь батлагдаж байна.

Газрын хэвлийн баялгийг ашиглах, хамгаалах харилцаанд хяналт тавих хууль тогтоомжийн олон улсын практикийг судлах явцад Монгол Улсаас өөр уул уурхайн салбарын гүйцэтгэх түвшний хэрэгжилтийг төрийн өөр хяналт-шалгалтын байгууллага гүйцэтгэдэг улс орон байсангүй бөгөөд хариуцлагатай уул уурхайн гол цөм нь салбарын төрийн төв болон захиргааны байгууллагын шууд удирдлага дор ажилладаг босоо тогтолцоотой мэргэжил, мэргэшлээр төрөлжсөн орон нутгийн салбар, уурхайн байцаагчийн үйл ажиллагаанд оршдог байна.

Тухайлбал, Швед улсын Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, хяналт болон ашигт малтмалын эрэх, хайх, олборлох, боловсруулах тусгай зөвшөөрөл олгох асуудал хариуцсан газрын төв байр нь Упсале хотод байрладаг бөгөөд Гетеборг, Лунд, Мало, Стокгольм, Лулео гэсэн 4-н хотод бүс хариуцсан орон нутгийн салбартай байдаг аж.

Зураг 2. Швед улсын Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, хяналт болон ашигт малтмалын эрэх, хайх, олборлох, боловсруулах тусгай зөвшөөрөл олгох асуудал хариуцсан газар



Газрын хэвлийг ашигт малтмал ашиглахаас өөр зориулалтаар ашиглах

10 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах зориулалт

1. Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгоно:
 - 1/геологийн судалгаа хийх
 - 2/ашигт малтмал олборлох
 - 3/ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах
 - 4/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах

“Газрын хэвлийн тухай” хуульд газрын хэвлийг ашиглах зориулалтыг заахдаа геологийн судалгаа хийх, ашигт малтмал олборлох, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын доор нефть хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, аж ахуйн нэгж байгууллагын бусад хэрэгцээг хангах гэж тусгажээ.

“Газрын хэвлийн тухай” хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших 30 гаруй жилийн хугацаанд газрыг хэвлийг ашиглах дээр дурдсан 4 төрлийн зориулалтаас **“аж ахуйн нэгж байгууллагын бусад хэрэгцээг хангах”** гэснээс бусад нь тус тусын харилцааг нарийвчлан зохицуулсан хуультай болж, хөгжиж иржээ. Тухайлбал: ашигт малтмал олборлохтой холбогдох газрын хэвлий ашиглах харилцааг Ашигт малтмалын тухай, Геодези, зураг зүйн тухай хуулиар, хортой бодис, үйлдвэрлэлийн хог хаягдлыг хамгаалан булах, барилга байгууламж барих харилцааг Барилгын тухай болон Хог хаягдлын тухай хуулиар зохицуулсан байна. Харин иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бусад хэрэгцээ буюу ашигт малтмал олборлох, хог хаягдлыг булах, бохир ус зайлуулах зорилгоор барилга байгууламж барихаас өөрөөр газрын хэвлийг ашиглах харилцаа нь “Газрын хэвлийн тухай” хуулийн зохицуулалтын хүрээнд бус (хэвлий ашиглах асуудал орхигдсон) бусад холбогдох хуулийн хүрээнд зохицуулагдаж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын бусад хэрэгцээг хангах харилцааг тус хуульд илүү тодорхой болгох үүднээс “Газрын хэвлийн тухай” хуулийн 15 дугаар зүйлд “ашигт малтмал ашиглуулахаас өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах” харилцааг томъёолсон байна. Хуульд заасан **“өөр зориулалт”** гэдэгт ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар **барилга байгууламж барих**, болон иргэн аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ахуйн болон аж ахуйн хэрэгцээндээ зориулан **өөр зориулалтаар** ашиглах боломжийг олгожээ.

Хууль тогтоогчоос иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хэвлийг ашиглах зориулалтыг тодорхой заалгүйгээр нээлттэй зохицуулжээ.

15.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй.

Энэ заалтын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж газрын хэвлийг ахуйн хэрэгцээндээ дараах байдлаар ашиглаж байна. (Хүснэгт 14)

Иргэд ахуйн хэрэгцээндээ:

- Зоорь барих
- Нүхэн жорлон, угаадасны нүх
- Худаг гаргах
- Усан сан барих

- Барилга байшингийн суурь
- Хог хаягдлыг булшлах

Аж ахуйн нэгж, байгууллага:

- Агуулах, зоорь
- Барилгын суурийн хэсэг, гараж
- Оршуулга
- Дулааны шугам
- Цэвэр усны шугам
- Кабель, холбооны шугам
- Туннель –хонгил, хоолой, нүхэн гарц
- Цооног гаргах зэрэг хэлбэрээр ашиглаж байна.

Хүснэгт 14. Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос бусад зориулалтаар ашиглах

Зориулалт	Холбогдох хуулийн зохицуулалт
Кабель, холбооны шугам	Газрын тухай хууль: 6.2.3.зам, шугам сүлжээний газар; 10.1.3.зам, шугам сүлжээний газар; Харилцааны холбооны тухай хууль: 28.1.Монгол Улсын газрын нэгдмэл сангаас холбооны сүлжээнд зориулан олгосон газар, орон зайг харилцаа холбооны хамгаалалтын зурвас газар гэнэ. Хамгаалалтын зурвас газар нь дараахь хэмжээтэй байна: 28.1.2.кабелийн шугамаас тал бүртээ 5 метр;)
Туннель – хонгил, хоолой, нүхэн гарц	Авто замын тухай хууль- 4.1.11."замын байгууламж" гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг; 20.3.Авто зам, замын байгууламжийг барих зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологи, угсаатны зүйн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна. 17.2.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон этгээд байна.
Дулааны болон цэвэр усны шугам, хоолой тавих	Газрын тухай хууль: 13.1.Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна. Эрчим хүчний тухай хуулийн 3.1.13."дулаан дамжуулах сүлжээ" гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг; 3.1.14."дулаан түгээх сүлжээ" гэж дулаан хуваарилах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг; 14.4.Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.
Барилгын суурийн хэсэг, В1,В2 давхар	Барилгын тухай хууль: 4.1.1."барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; Хонгилын систем (барилгын норм ба дүрэм- БНБД 44-04-21): 4.2. Барилга байгууламжийн газар доорхи ашиглалтыг зөв зохистой төлөвлөх, хотын инженерийн шугам сүлжээний аюулгүй байдал хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг хангах, эдийн засгийн үр ашигтай, ашиглалтын зардал багатай, дэвшилтэт техник технологи ашиглаж ажил гүйцэтгэх болон засвар үйлчилгээ хийхэд хялбар байх шаардлагыг бүрдүүлнэ.
Нүхэн жорлон,	Нүхэн жорлон, угаадасны нүх ашиглах (техникийн шаардлага буюу стандарт MNS5924:2015)

угаадасны нүх ашиглах	Төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн хэрэгцээнд хэрэглэх зориулалттай нүхэн жорлон, угаадасны нүхний зураг төсөл зохиох, барьж ашиглах, хяналт тавихад энэхүү стандартыг мөрдөнө.
Оршуулгын байгууламж	Газрын тухай хууль 12.2.Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна. MNS стандарт – 4.3.1 Оршуулгын газар нь хил хязгаар тогтоосон шав, тэмдэглэгээтэй, кадастрын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, гэрчилгээгээр баталгаажсан, хариуцах этгээдтэй байна. 4.3.2 Оршуулгын газрын хамгаалалтын бүсийг батлагдсан хил хязгаараас 300 метрээс багагүй хэмжээний зурвасыг эрх бүхий байгууллагаар тогтоолгосон байна. 4.4 Оршуулгын байгууламжид тавих шаардлага 4.4.1 Булшны байгууламж Газрын хөрсөнд оршуулах булшны нүх нь дараах шаардлагыг хангана: а. Нүхний гүн газрын гадаргаас хэмжсэнээр 1,5 метрээс ихгүй, б. Шарил хоорондын зай, булангийн ирмэгээс хэмжсэнээр 2,0 метрээс ихгүй, с. Газрын хэвлий налуу бус эгц доош ухагдсан байх,
Хог хаягдлын байгууламж	Хог хаягдлын тухай хууль: 4.1.22.“ландфилл” гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг; 16.7.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн байршлыг хэд хэдэн аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран тогтоож болно. 16.8.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулахыг хориглоно. 19 дүгээр зүйл. Ландфиллыг хаах 19.1.Ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хааж болно.

Ийнхүү дээр дурдсанаар ашиглах эрх нь “Газрын хэвлийн тухай” хуульд заасны дагуу үүсэх ёстой ч практикт Газрын тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу үүсэж байна. /Барилгын тухай, Авто замын тухай, Эрчим хүчний тухай, Хог хаягдлын тухай, Байгаль орчны тухай, Усны тухай гэх мэт / Иргэд аж ахуйн нэгж дээр дурдсан зориулалтаар газрын хэвлийг ашиглахдаа эрх бүхий этгээдээс газрын хэвлий ашиглах зөвшөөрөл авдаггүй, газрын хэвлийг чөлөөтэй ашиглаж байна. Харин газрын хэвлий ашиглах үйл ажиллагааны хүрээнд холбогдох бусад хуульд заасны дагуу зөвшөөрөл авах, шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авч байна.

15 дугаар зүйл. Ашигт малтмал олборлох, газар доор нефть хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахаас өөр зориулалтаар ашиглуулахаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно:

1/ улсын болон аймаг нийслэлийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн аймаг нийслэлийн засаг дарга;

2/орон нутгийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн сум дүүргийн засаг дарга олгоно.

Практикт иргэн аж ахуйн нэгж байгууллага нь барилга байгууламж барихдаа Газрын тухай хууль болон Барилгын тухай хуульд заасны дагуу газар эзэмших, ашиглах

зөвшөөрөл авдаг. Энэхүү газрын зөвшөөрлийг үндэслэн тухайн барилгын техникийн нөхцөл болон барилга эхлэх, ашиглалтад оруулах зэрэг бусад зөвшөөрлүүд олгогддог. Харин барилга байгууламжийг барихад “Газрын хэвлийн тухай” хуулийн 15 дугаар зүйлд заасан газрын хэвлий ашиглах эрхийг Засаг даргаас олгох зөвшөөрөл гэж байхгүй ба барилга барих зөвшөөрөл болон газрын зөвшөөрлийн хүрээнд шийдвэрлэгддэг. Хуульд заасан энэхүү зөвшөөрлийг олгохтой холбогдсон журам байхгүй байгаагаас тодорхой бус, зохицуулалтгүй байна /Зөвшөөрлийг гэрчилгээгээр нотлогдох эсэх, ямар хугацаагаар олгох зэрэг нь гэх мэт зүйл тодорхойгүй/. Ихэнх барилга суурь хэсгээрээ газрын хэвлийд бэхлэгдэж баригдсан, газрын хэвлийд 1-5 давхар баригдсан байгаа боловч тэдгээр нь газрын хэвлий ашиглах тухай хуультай хамааралгүй байдлаар зохицуулагдаж байна. Энэ нь барилга байгууламжийн хувьд газрын хэвлийг ашиглаагүй, тус хуулийн зохицуулалтад хамаарахгүй гэдэг ойлголт төр болон иргэдийн хэн алинд тогтсон гэж үзэхээр байна.

Харин газраас ил гараагүй, газар доор барьсан бие даасан барилга байгууламжийн хувьд газрын хэвлийг ашиглах зөвшөөрөл олгогдох уу, эсвэл энэ нь дээр дурдсан барилга байгууламж барих, болон газрын тухай хуульд заасан эрхийн хүрээнд хэрэгжих үү гэдэг нь мөн л тодорхойгүй буюу практикт газрын доор барилга байгууламж барих газрын хэвлий ашиглах зөвшөөрөл олгогддоггүй, түүнийг олгох үндэслэл журам тодорхойгүй байна.

А барилгын компанийн захирлаас барилга байгууламж барихдаа газрын хэвлий ашиглах зөвшөөрөл авдаг эсэх талаар асуухад ийм зөвшөөрөл авдаггүй, манайх газрын хэвлийг ашиглаагүй, газар ашигладаг гэж хариулсан.

“Газрын хэвлийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дах хэсгүүд практикт огт хэрэгждэггүй байна. Газар доорх барилга байгууламжийг бүртгэж, зөвшөөрөл олгох, хяналт тавих зохицуулалтууд хэрэгждэггүй тул газрын хэвлийг хамгаалах асуудал мөн орхигдож байгаа юм.

Цаашид “Газрын хэвлийн тухай” хууль батлагдсан зорилго нь газрын хэвлий ашиглах, түүнд төр өмчлөгчийн хувьд хяналтаа тавих болон хот байгуулалт, газар төлөвлөлт, байгаль орчин болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангах зорилгодоо хүрч чадаагүй нөхцөл байдлууд харагдаж байна.

“Газрын тухай хууль”-ийн 55 дугаар зүйлээр газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан байна. Тус хуулийн 55.1-д “Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна” гэж заасан нь төлөвлөлтийн зарчимтай нийцэж байна. Мөн тус хуулийн 55.2-т “Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна”, 55.3-т “Газрын хэвлийг ашиглагч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ” гэж заасан боловч нарийвчилсан, ерөнхий үнэлгээний аль нь болохыг тодорхойлоогүй байна. Мөн тус хуулийн 55.4-д “Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, түүнд үндэслэсэн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулна” гэсэн зохицуулалт огт хэрэгждэггүй бөгөөд үүнийг БХБЯ-аар батлуулах нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй зохицуулалт болсон байна.

Тус хуулийн 41.1.1-д “Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ” гэж заасан ба экологийн магадлан шинжилгээ гэдэгт ямар үйл ажиллагаа хамаарах нь тодорхойгүй байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 43.1 дэх хэсэгт зааснаар “Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн

болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна” гэж заасан байна. Харин тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зөвхөн “шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрыг” тусгай хамгаалалтад авахаар тусгасан ба Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын асуудлыг орхигдуулсан байна.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдсан байна. Энэхүү хуулиар зарим төрлийн хог хаягдлыг булж устгах, ландфилд булшлахыг хориглосон байна. Иймд “Газрын хэвлийн тухай” хуульд зарим бодисыг булах тухай зохицуулалт орсон байгаа нь Хог хаягдлын тухай хуультай нийцэхгүй байна. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 15.4-15.7 дэх хэсгүүдийг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэх нь зүйтэй байна.

2.4. Газрын хэвлий ашиглахтай холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн ерөнхий дүн шинжилгээ

1. Судалгааны арга зүй, судалгааны түүвэр

“Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ Монгол Улсын шүүхээс “Газрын хэвлийн тухай” хуулийг хэрэглэсэн шийдвэр, тохиолдлуудад дүн шинжилгээ хийх нь ач холбогдолтой гэж үзлээ.

“Газрын хэвлийн тухай” хууль нь 1988 онд батлагдаж газрын хэвлийг ашиглах суурь харилцааг зохицуулж ирсэн бөгөөд 1994 онд 1 удаа нэмэлт өөрчлөлт орсноос өөрөөр шинэчлэгдэж өөрчлөгдөөгүй хууль юм.

Нийгэм, эдийн засгийн харилцаа хөгжих явцад газрын хэвлий ашиглах харилцааг илүү нарийвчлан зохицуулах шаардлага тулгарч ашигт малтмалын тухай, болон холбогдох бусад хууль батлагдаж¹³ газрын хэвлий ашиглах асуудлыг зохицуулж байна. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш түүний зорилгодоо хүрсэн байдал, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь цаг хугацааны болоод эрх зүйн актын хүлээн зөвшөөрөгдөх шаардлагын хүрээнд тулгамдаж байгаа болно.

Судалгааны хүрээнд www.shuukh.mn сайтад байрлуулсан шүүхийн шийдвэрээс “Газрын хэвлийн тухай” хуулийг хэрэглэсэн 2018-2021 оны хооронд шийдвэрлэгдсэн, нийт 14 хэргийг түүвэрлэн авч судалсан болно. Түүвэрт анхан шатны шүүхийн 6, давж заалдах шатны 3, Хяналтын шатны 5 шийдвэр багтсан бөгөөд бүх шийдвэр захиргааны хэргийн шүүхэд хамаарч байна.

Юуны түрүүнд түүвэрлэсэн шүүхийн шийдвэрээс “Газрын хэвлийн тухай” хууль ямар төрлийн маргаанд түлхүү хэрэглэгдэж байна, хуулийн ямар зүйл заалт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа талаар ерөнхий байдлаар тоймлон харах, практикт хууль хэрэглээ ямар байгаад ерөнхий дүгнэлт өгөх бөгөөд тухайн нэг шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлд дүн шинжилгээ хийхэд чиглээгүй болно. Дээр дурдсан шүүхийн шийдвэрүүдээс “Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагавар, хуультай холбоотой маргааны төрөл, онцлог, шийдвэрлэж байгаа шүүхийн практик, хууль хэрэглээний онцлог зэргийг харуулахыг зорьсон болно.

2. Дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас “Газрын тухай хууль”-ийг хэрэглэсэн 14 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн үзэхэд 13 хэрэг нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

¹³ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тухай хууль, Газрын тосны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай, Геодези зураг зүйн тухай, Газрын тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Зөрчлийн тухай, Барилгын тухай хууль, Эрүүгийн хууль гэх мэт

цуцалсантай холбоотой, 1 хэрэг нь ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгохыг даалгах тухай агуулгаар гаргасан нэхэмжлэл бүхий захиргааны хэрэг байв.¹⁴

Эдгээр шийдвэр нь ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй этгээд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, сумын засаг даргын захирамж, иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолд холбогдуулан гаргасан нэхэмжлэл хамаарч байна.

Түүвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд “Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1 дэх хэсэг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар бүрэн эрх, 21 зүйл. Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох, 7 зүйл. Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурал болон Засаг даргын бүрэн эрх, 8 зүйл. Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын бүрэн эрх, 10 зүйл. Газрын хэвлийг ашиглах зориулалт, 13 зүйл. Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох тухай зүйл заалтууд хэрэглэгдэж нэхэмжлэгч хариуцагчийн тайлбар болон шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт дурдагджээ.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дийлэнх нь “Газрын хэвлийн тухай” хуульд заасан \12 зүйлд\ газрын хэвлий ашиглах 4 зориулалтаас ашигт малтмал олборлохтой холбоотой буюу “Газрын хэвлийн тухай” хуулийн 21-р зүйлд заасан ашиглах эрхийг дуусгавар болгосонтой холбоотой, бусад 2 шийдвэр нь газрын хэвлий ашиглах зөвшөөрөл гаргуулахтай холбоотой шийдвэр байв.

Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар “Газрын хэвлийн тухай” хуулийн 21.2.1-т заасан газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй болон 21 зүйлийн 1 дэх хэсгийн 5 заасан хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон гэх зүйл заалтыг удирдлага болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгож улмаар газар ашиглах зөвшөөрлийг цуцалсан шүүхийн шийдвэрүүд давамгайлж (12 шийдвэрт энэ үндэслэлийг дурджээ) байна.

- Газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй гэх үндэслэлийн талаар:

Эрх бүхий этгээдээс газар ашиглах эрхийг цуцлахдаа газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй гэдэгт үндэслэж шийдвэр гаргадаг ба үүнийгээ шүүхэд хамгаалахдаа газрын хэвлийг бодитоор ашиглаагүй ухаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэдэг байдлаар тайлбарлаж нотолдог. Ихэнх тохиолдолд мэргэжлийн хяналтын байцаагчийн акт баримт, шүүхийн үзлэгээр нотлогдож байна.

“Ашиглаж эхлэх” гэдгийг шүүхээс тодорхойлохдоо газрын хэвлийг бодитоор ашигласан эсэхийг үнэлж байгаа бөгөөд бодитоор ашиглаагүй, газрыг ухаагүй, дээр доор нь аливаа зүйл бариагүй, ямар нэг хэлбэрээр ашиглаагүй бол ашиглаж эхлээгүй гэж үзэж байгаа бөгөөд газар ашиглах, ашигт малтмал олборлохтой холбоотой аливаа зөвшөөрөл, үнэлгээ хийх гэх мэт ажлыг “ашиглаж эхэлсэн” гэж үзэхгүй байна.

- 21 зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон гэх үндэслэлийн талаар:

Ашигт малтмал ашиглах эрхийг дуусгавар болгохдоо хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон гэх үндэслэл нь шүүх дээр ихэнх тохиолдолд няцаагдаж байсан бөгөөд хариуцагч нь гаргасан шийдвэрээ хамгаалах үйл баримтыг хангалттай тодорхойлж, нотлох ажиллагааг дутуу хийж, хөндлөнгийн

¹⁴ Шүүхийн шийдвэрийн түүврийн жагсаалтыг Хавсралт 2-оос харна уу.

байгууллагын дүгнэлт гаргуулах гэх мэт ажиллагааг хийгээгүйгээс шийдвэр нь хүчингүй болж байна. Хүн амд аюултай байдал бий болсон гэдгийг шүүхээс авч үзэхдээ бодит аюул бий болсон эсэх, тэр нь тогтоогдож байгаа эсэх, хор хохирол учирсан эсэх, иргэд гомдол мэдээлэл гаргах зэргээр эрхээ хамгаалах үйл ажиллагаа явуулсан эсэх дээр дүгнэлт өгч, шийдвэрлэж байна.

- Мөн газрын хэвлий ашиглах харилцааг дуусгавар болгох журам, үндэслэл харьцангуй ерөнхий зохицуулагдсан, дуусгавар болгохоос өмнө хийгдэх урьдчилан сануулах, анхааруулах, зөрчлөө арилгах зэрэг ажиллагааны талаар зохицуулалт байхгүй /ашиглагчийн эрхийг хамгаалах/ байгаа нь нэг талаас газрын хэвлий ашиглагчийн эрхийг зөрчих, их хэмжээний хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлаар хохирох, нөгөө талаас эрх бүхий засаг даргын үзэмжээс хамаарах зэрэг үр дагаврыг үүсгэж байгаа талаар нэхэмжлэгч хариуцагч талын тайлбараас харагдаж байна.

“Газрын хэвлийн тухай” хуулийн ашигт малтмал ашиглах, олборлох зориулалтаас бусад хэсгүүдээр гарсан шүүхийн шийдвэр цахим сангаас олдоогүй буюу хайлтад илрээгүй болно.

2.5. Хууль тогтоомжийн уялдаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/67 дугаар тушаалаар “Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг “Газрын хэвлийн тухай” хуульд дүн шинжилгээ хийж, нийт 27 давхардал, 21 зөрчил, 15 хийдэл байгааг тогтоож хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байгааг тодорхойлсон. Энэхүү судалгааг Хавсралт 2-т хавсаргав.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Газрын хэвлийн тухай” хуулийг анх 1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн зарлигаар баталснаас хойш эдүгээ 33 жил өнгөрсөн байна. 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг баталж эрх зүйн шинэтгэлийг эхлүүлсэн. 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль болон түүний хавсралт хуульд зааснаар хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан дуусгах зорилтыг тавьсан.

Тухайн үед уг хууль нь газрын харилцаа, ашигт малтмал хайх, олборлох, газрын гүнд барилга байгууламж барих үйл ажиллагаа, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах харилцааг дангаар зохицуулж байсан бөгөөд дараах хуулиудыг баталснаар “Газрын хэвлийн тухай” хуулиар зохицуулагдаж байсан харилцаа тус тусын нарийвчилсан хуулиар зохицуулагдах болсон байна. Тухайлбал:

- 1994 онд Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаар “Газрын хэвлийн тухай” хуулиар зохицуулж байсан ашигт малтмалтай холбогдох харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар;
- 1998 онд Барилгын тухай хууль батлагдсанаар Барилга, байгууламж барих харилцааг тус хуулиар;
- 2012 онд Хог хаягдлын тухай хуулийг баталснаар хог хаягдлын асуудлыг тус хуулиар;
- Аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын бүрэн эрхийн асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар;
- Төрийн байгууллагын хяналтын асуудлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар;
- Байгаль орчныг хамгаалах асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай асуудлыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар;
- Соёлын өвийн асуудлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар;
- Усны асуудлыг Усны тухай хуулиар;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Ийнхүү дээр дурдсанаар Газрын хэвлийн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиудыг баталсан боловч “Газрын хэвлийн тухай” хуультай нийцүүлэх ажлыг хийгээгүйгээс тус хуульд тусгагдсан зохицуулалтууд бусад хуулиудтай зөрчилдөх, байгууллагуудын чиг үүрэг давхардах эсхүл зөрчилдөх болсон байна. Улмаар “Газрын хэвлийн тухай” хуулийн зохицуулалт нь өнөөгийн зах зээлийн эдийн засгийн болон нийгмийн хөгжил, төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалт болон бусад хууль тогтоомжтой нийцэхгүй, ихэнх зохицуулалт нь хэт ерөнхий, тунхаглалын шинжтэй болсон байна.

“Газрын хэвлийн тухай” хуулийн бусад хуультай нийцэж байгаа эсэх талаар хийсэн судалгаанаас үзэхэд бусад хууль тогтоомжид тус хуулийг нийцүүлэхийн тулд нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахаар заасан тул “Газрын хэвлийн тухай” хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж байна. (Хавсралт 2)

Нэгэнт, тус хуулийн олон зүйл заалт нь хожим нь батлагдсан салбар хуулиуд болох Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн заалтуудтай давхардах, эсхүл тэдгээртэй харилцан уялдаагүй, зөрчилтэй зүйл заалт ч цөөнгүй байгаагаас тус хуулиар газрын хэвлийг бүхий л зорилго, зориулалтаар судлах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан нийтлэг зохицуулалт бүхий суурь хууль байдлаар шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзнэ.

- Хууль тогтоогч “Газрын хэвлийн тухай” хуулийг батлахдаа газрын хэвлийн ашиглалтын асуудлыг газар ашиглалтын асуудлаас тусгайлан зохицуулж цаашид газрын хэвлий ашиглах асуудлыг хөгжүүлэх зорилготой байсан боловч Уул уурхай, ашигт малтмал олборлох, геологийн судалгаа хийхээс бусад буюу “өөр зориулалтаар” газрын хэвлийн ашиглах асуудал нь хуулийн зорилгодоо хүрч чадаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.
- “Газрын хэвлийн тухай” хуулиар Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болохоор зааснаас гадна, газрын хэвлийг хугацаатай болон хугацаагүйгээр ашиглалтад олгож болохоор буюу хугацаагүйгээр ашиглалтад олгосон тохиолдлыг түрээслэн ашиглах гэж ойлгохоор заасан нь одоогийн Ашигт малтмалын тухай хуулиар ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсад үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд олгохоор заасан, ашиглалтын тусгай зөвшөөрөл нь зайлшгүй хугацаатай байх зэрэг зарчимтай зөрчилдөж байгааг нэг мөр болгон өөрчлөх нь зүйтэй байна.
- “Газрын хэвлийн тухай” хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолтуудыг нарийвчлах, бусад хуулийн зүйл, заалттай нийцүүлэн тусгаар тогтнол, үндэсний язгуур ашиг сонирхлын тулгуур болсон газрын хэвлийн тухайд нэгдсэн бодлого, зохицуулалттай байх явдлыг эрх зүйн хүрээнд бэхжүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна.
- “Газрын хэвлийн тухай” хуулиар геологийн судалгаа хийхийг газрын хэвлийг ашиглах ойлголтод хамруулж байгааг Ашигт малтмалын тухай хуулиар болон бусад салбар хуулиар тодорхойлсон “ашиглах” ойлголтой нийцүүлэн “газрын хэвлийн судалгаа”-г “газрын хэвлийн ашиглалт”-аас ангид байдлаар зохицуулах нь зүйтэй байна. Газрын хэвлийн судалгаа нь тойм судалгаа, эрэл, ашиглалтын өмнөх болон ашиглалтын явцын хайгуул гэсэн үндсэн дөрвөн төрлийн судалгаанаас бүрдэх бөгөөд тэдгээрээс тойм судалгаа болон эрлийг тусгай зөвшөөрөлгүйгээр бүртгэл-удирдамжийн үндсэн гүйцэтгэх нь зүйтэй.
- Газрын хэвлийн судалгаа, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, үр дүн, тайлан, мэдээ мэдээллийн санг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар бүрдүүлэн хөтлөх ажил өрөөсгөл түвшинд явж ирсэн нь эрх зүйн болон төрийн байгууллагын хоорондын уялдаа, нэгдмэл байдал алдагдаж ирсэн буюу газрын хэвлийн талаар төрийн нэгдсэн төлөвлөлт, бодлого, судалгааны институт байхгүй байсантай холбоотой юм. Энэ байдлаас үүдэн газрын хэвлийг судлах, урт хугацааны нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд ашиглах боломж, газрын хэвлийн ашигт чанарыг, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлага, улс болон орон нутгийн хөгжил, газар төлөвлөлт, дэд бүтэц, хот байгуулалтын бодлого, үйл ажиллагаатай харилцан уялдаа суларсан байна гэж үзэж болох юм.
- Мөн газрын хэвлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг буюу олон улсын жишгээр “Үндэсний геологийн алба”-ыг байгуулах талаар өнгөрсөн хугацаанд маш олон бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төлөвлөгөө, Ашигт малтмалын тухай хуульд зорилт, зүйл заалтууд тусгаж ирсэн ч эрх зүйн орчныг нь шаардлагатай хэмжээнд тодорхойлж чадаагүй нь санхүү, төсвийн боломжоос шалтгаалсан байна. Энэ бүхэн нь шууд бусаар газрын хэвлийн төрийн бодлого зохицуулалтыг улсын хэмжээнд нэгдсэн

байдлаар тодорхойлох, хэрэгжилтийг хангахад бэрхшээл учруулсаар ирсэн байна.

- Монгол улсын төрөөс баталсан эрдэс баялгийн, эрчим хүчний, экологийн, газрын тосны, цөмийн эрчим хүчний, усны зэрэг олон тусдаа бодлогуудыг газрын хэвлий гэсэн нэгэн утгаар нь харилцан уялдаатай болгох шаардлага байна.
- Газрын хэвлийн тухай нэр томьёо нь хуулийг хэрэглэх хүрээ, зохицуулах харилцааг тодорхойлж байгаа боловч тухайн нэр томьёоны агуулга амьдралд хэрэгжиж буй байдал нь хоёр зөрүүтэй буюу газрын хэвлийг иргэд, олон нийт газрын гүний хэсэг буюу уурхай, ашигт малтмал олборлохтой холбон ойлгож байна. Өөрөөр хэлбэл “газрын хэвлий” гэх нэр томьёо нь оновчтой бус байна. Иймээс газрын хэвлийн тухай ойлголтыг оновчтой тодорхойлох ялангуяа газрын тухай хуульд заасан “газар” гэх ойлголтоос ялгах, тэдгээрийг хэмжих боломжтой байхаар хуульчлах шаардлагатай байна.
- “Газрын хэвлийн тухай” хуулийн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлий ашиглахтай холбоотой асуудлыг эрх бүхий төрийн байгууллагууд анхаарлын гадна үлдээж, ач холбогдол өгдөггүй, хуульд заасан бүртгэл хийх, зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийх эрхээ хэрэгжүүлдэггүйгээс үзэхэд “Газрын хэвлийн тухай” хуулийн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлий ашиглахтай хэсэг практикт огт хэрэгждэггүй, хууль зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй буюу хэрэглэхгүй байна. Тиймээс газрын хэвлийг ашиглах зориулалтыг газрын хэвлий гэх ойлголттой уялдуулах, газрын хэвлий ашиглах зөвшөөрлийг бусад холбогдох хуулиар олгох зөвшөөрөлтэй уялдуулах эсхүл хуулиас хасахыг зөвлөж байна.
- Газар доорх барилга байгууламж гэдэг ойлголтыг тодорхой тусгах, газрын доор бэхлэгдэж, тодорхой хэсэг нь газар доор баригдсан барилга байгууламж хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарах эсэх, эсхүл зөвхөн бүх хэсэг нь газрын доор баригдсан барилга байгууламжид хамааралтай эсэхийг тодорхой болгох шаардлагатай.
- Цаашид газрын хэвлийг төлбөртэй ашиглах эсэхийг тодорхойлж түүнийг практик хэрэгжих нөхцөлийг хуульд тусгах нь зүйтэй.
- Газрын хэвлий ашиглах талаарх ойлголт иргэд, олон нийтийн дунд тааруу байна. Газрын хэвлийн хуулийн үзэл баримтлалыг эргэн харж амьдралд хэрэгжих, амьтай болгох, огт хэрэгждэггүй заалтуудыг хасах эсвэл дахин шинээр томьёолох шаардлагатай байна.
- “Газрын хэвлийн тухай” хуулийг хэрэглэж байгаа шүүхийн практикаас харахад ихэвчлэн ашигт малтмал олборлох, ашиглах, газар эзэмших зөвшөөрөлтэй холбоотой, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 зүйлд заасан газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгохтой холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргадаг байна. Энэ нь ч энэ хуулийг зөвхөн ашигт малтмалтай холбоотой хууль мэтээр ойлгогдож хүлээн зөвшөөрөгдөх болсныг харуулж байна.
- “Газрын хэвлийн тухай” хууль нь ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг цуцлах, газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгох /4,21, 10, 7, 8 зүйл/ үндэслэл болж байгаа бөгөөд газрын хэвлий тухай хуулийн дээрх заалт, түүнтэй холбоотой бусад заалтыг шүүх болон төрийн байгууллагууд идэвхтэй хэрэглэж шийдвэр гаргаж байна.
- Цаашид газрын хэвлийг ашиглах, түүнийг дуусгавар болгоход талуудын эрх ашгийг хамгаалах, эрх үүргийг ялангуяа ашиглагчийн эрхийг тодорхойлох, хамгаалах талаар зохицуулалт оруулах шаардлагатай байна.
- Харин газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос бусад зориулалтаар ашиглахтай холбоотой маргаан гарах нь бага, гарч байсан эсэх нь тодорхойгүй шүүх газрын хэвлийн хуулийг дээр дурдсанаас бусдаар хэрэглэх практик хангалтгүй байна. Үүнийг анхаарч хуульд газрын хэвлий ашиглах талаар хууль зүйн ойлголтыг нийтэд ойлгуулах, сурталчлах хэрэгтэй байна.

Хавсралт 1. Шүүхийн шийдвэр

Хэргийн төрөл	Огноо, дугаар	Хуулийн зүйл, заалт	Хэргийг шийдсэн
НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2020 оны 05 сарын 21 өдөр Дугаар 128/ШШ2020/0350	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1	Түдгэлзүүлсэн
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ	2021 оны 05 сарын 28 өдөр Дугаар 221/МА2021/0274	“Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 37 дугаар зүйлийн 37.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5	Гомдлыг хангахгүй орхисон
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ	2021 оны 07 сарын 28 өдөр Дугаар 221/МА2021/0412	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3, 37.2, 37.6, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1	
ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ “Т” ХХК- ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох Захиргаа ны хэргийн тухай улсын дээд шүүхийн тогтоол	2020 оны 10 сарын 26 өдөр Дугаар 389	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.3, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1	Хэвээр үлдээх
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ “Э” ХХК- ийн нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн тухай	2021 оны 05 сарын 13 өдөр Дугаар 221/МА2021/0228	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1	Буцаах
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ “М” ХХК- ийн нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн тухай	2020 оны 12 сарын 20 өдөр Дугаар 221/МА2020/0636	“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1	Буцаах

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2021 оны 03 сарын 16 өдөр Дугаар 128/ШШ2021/0185	Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 37 дугаар зүйлийн 37.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5	Хүчингүй болгох
НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2020 оны 04 сарын 23 өдөр Дугаар 128/ШШ2020/0265	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 37 дугаар зүйлийн 37.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1	Хэрэгсэхгүй болгох
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ “С” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Хан-Уул дүүргийн Засаг даргад Холбогдох захиргааны хэргийн тухай	2019 оны 04 сарын 22 өдөр Дугаар 121	“Газрын хэвлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 13 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн 21.5.3, 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн 31.1.4, Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.16, 4.1.18, 4.1.19, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн 35.3.7	Гомдлыг хангахгүй
НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2021 оны 05 сарын 24 өдөр Дугаар 128/ШШ2021/0362	“Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2, 4, 21 дүгээр зүйлийн 1, 5	Нэхэмжлэлийг хангав
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ “С” ХХК, “Ц” ХХК- уудын Нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай	2021 оны 05 сарын 13 өдөр Дугаар 221/МА2021/0231	“Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5	Хэвээр үлдээх
НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2021 оны 01 сарын 18 өдөр Дугаар 128/ШШ2021/0043	“Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2	Нэхэмжлэлийг хангасан

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2018 оны 12 сарын 11 өдөр Дугаар 801	“Газрын хэвлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 13 дугаар зүйл	Хэрэгсэхгүй болгох
НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР	2021 02 09 Дугаар 128/ШШ2021/0119	“Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5	Холбогдох хэсгийг хүчингүй болгох
УДШ-ИЙН ШИЙДВЭР	2019 12 18 №433	Газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгосон ГХТХ-ийн 21.2.1	Шийдвэр магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ	2019 02 13	ГХТХ-ийн 8.2.2 баримтлан гаргасан нэхэмжлэл гаргасан	Хангахгүй орхисон

Хавсралт 2. Хууль тогтоомжийн үйлдвэр

“Газрын хэвлийн тухай” хууль 1988 онд батлагдсан бөгөөд тухайн үед ашигт малтмалтай холбогдох харилцааг уг хуулиар зохицуулж байсан. Улмаар 1994 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Ашигт малтмалын тухай анхны хуулийг баталсан байна.

Ашигт малтмалын тухай хууль батлагдсаны дараа 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Газрын хэвлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан ба эдгээрийн нэг нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 буюу “Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна” гэсэн хэсэг юм. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулсан боловч “Газрын хэвлийн тухай” хуульд газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулсан хоёрдугаар бүлэг “Газрын хэвлийн геологийн судалгаа”, гуравдугаар бүлэг “Ашигт малтмалыг олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах”, дөрөвдүгээр бүлэг “Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах” гэсэн зохицуулалтууд одоо болтол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өөрөөр хэлбэл, “Газрын хэвлийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг нь уг хуулийн 2, 3, 4 дүгээр бүлгүүдтэй бүхэлдээ зөрчилдөж байна.

Мөн уг хуулийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газрын холбогдох мэргэжилтнүүд уг хуулийг үйл ажиллагаандаа мөрддөггүй гэсэн ба учир нь Ашигт малтмалын тухай хуультай ихэнхи зүйл заалтын хувьд зөрчилддөг гэж тайлбарлаж байна.

“Газрын хэвлийн тухай” хууль	Холбогдох хууль	Санал
1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.		
2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль тогтоомж 1. “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> 2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.		

/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/		
3 дугаар зүйл.Монгол Улсын газрын хэвлий бол төрийн өмч Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн. Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.	УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 09-нд баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд 1992 оны Үндсэн хуулийн 6.2-т байсан “төрийн өмч” гэсэн агуулгыг “Төрийн нийтийн өмч” тодотгосон. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 3-р зүйлд “...Газрын хэвлий төрийн өмч” гэснийг Үндсэн хуульд нийцүүлж “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх нь зүйтэй байна.	Үндсэн хуульд нийцүүлж өөрчлөх
4 дүгээр зүйл.Газрын хэвлий, түүний улсын нэгдмэл сан 1.Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ. 2.Газрын хэвлий нь ашиглаж байгаа эсэхээс үл хамааран бүхэлдээ улсын нэгдмэл санг бүрдүүлнэ. /Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/		“Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1-т “Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ”, 3-р зүйлд “...Газрын хэвлий нь төрийн өмч” гэж зааснаас тус тус үзэхэд Газрын хэвлийд байгаа барилга байгууламж төрийн өмч байхаар ойлгогдож байна. Энэ нь Үндсэн хуулийн 5.2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалттай, 16.3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэсэн заалттай тус тус зөрчилдөж байна. Мөн Газрын хэвлийд байгаа барилга байгууламж барих, тухайлбал газрын хэвлийд туннель, гараж барих зэрэг нийгмийн хөгжлийн зайлшгүй шаардлагаар бий болж буй хэрэгцээг зохицуулахад хүндрэл учруулж байна.

		“Газрын хэвлийн тухай” хуулийн 4.1-г өөрчлөн найруулах
6 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи үйл ажиллагааг төрөөс удирдах 1.Улсын Их Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг тодорхойлох; 2/газрын хэвлийн улсын нэгдмэл санг захиран зарцуулах бодлогын үндсийг тодорхойлж, чиглэлийг тогтоох; 3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	Үндсэн хууль Хорин тавдугаар зүйл 1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; 2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;	Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу УИХ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох бүрэн эрхтэй. “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.1.1-т “УИХ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг тодорхойлох” гэж заасан нь Үндсэн хуулийн дээрхи зохицуулалттай агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.1.1, 6.1.2 дах заалтуудыг тус тус хүчингүй болгох
2.Засгийн газар газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах; 2/газрын хэвлийг ашиглах, хамгаалах техникийн нэгдсэн бодлогыг тодорхойлох; 3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	Үндсэн хууль Гучин наймдугаар зүйл 2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль 9.3.Засгийн газрын бүрэн эрх: 9.3.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Засгийн Газар Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах, төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.2.1-т “Засгийн Газар газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах” гэж заасан нь Үндсэн хуулийн дээрхи зохицуулалттай агуулгын хувьд давхардсан байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9.3.2-т заасны дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын

		хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулах Засгийн газрын бүрэн эрх нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.2.2-той давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.2.1, 6.2.2 дах заалтуудыг тус тус хүчингүй болгох
3.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/газрын хэвлийн баялаг, эрдэс түүхий эдийг зохистой ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх; 3/газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх; 4/ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгох; 5/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль 7 дугаар зүйл. Яамны нийтлэг эрхлэх асуудал 7.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг ажил эрхэлнэ: 7.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; Ашигт малтмалын тухай хууль 10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, биелэлтийг хангах; Ашигт малтмалын тухай хууль 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.14.хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих;	Яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Яам (төрийн захиргааны төв байгууллага) нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах үүрэгтэй. Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1 дэх заалт “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.1-т “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах” гэж заасантай давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.1 дахь заалтыг хүчингүй болгох “Газрын хэвлийн тухай” хууль нь 1988 онд батлагдсан. Тухай үед Ашигт малтмалын тухай хууль батлагдан гараагүй байсан ба төрийн захиргааны төв байгууллага нь “газрын хэвлийн баялаг, эрдэс түүхий эдийг зохистой ашиглах

	11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ. Ашигт малтмалын тухай хууль 6 дугаар зүйл. Ашигт малтмалын ордын ангилал 6.1.Ашигт малтмалын ордыг дор дурдсанаар ангилна: 6.1.1.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд; 6.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын орд; 6.1.3.ердийн ашигт малтмалын орд. 6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан ордод мөн хуулийн 4.1.12-т заасан шалгуур хангасан ордыг хамааруулна. /Энэ хэсэгт 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 6.3.Барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий хурдас, чулуулгийн хуримтлалыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод хамааруулна. 6.4.Энэ хуулийн 6.2, 6.3-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын хуримтлалыг ердийн ашигт малтмалын ордод хамааруулна.	бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх” эрхийг хэрэгжүүлж байсан. Харин Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаар уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтад агуулгын хувьд ижил утгатай заалтыг хуульчилсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг хүчингүй болгох. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.14-д заасны дагуу нэгдсэн хяналтыг “төрийн захиргааны байгууллага” хэрэгжүүлнэ гэсэн нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.3-т “төрийн захиргааны төв байгууллага” дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасантай зөрчилдөж байна. Мөн Ашигт малтмалын тухайн хуулийн 11.3 дэх хэсэгт Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэхээр заасан нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.3 дахь заалттай газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах үед хэн хяналт тавих нь зөрчил үүсгэж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтыг хүчингүй болгох. Ашигт малтмалын тухай хуулийн 6-р зүйлд зааснаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын
--	--	--

		орд, түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, ердийн ашигт малтмалын орд гэж ангилна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.4-т ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгохоор заасан нь Ашигт малтмалын тухай хуультай зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалтыг хүчингүй болгох.
4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд төрийн хяналт тавих; 2/газрын хэвлийг зохистой ашиглуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. /Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	Яамны эрх зүйн байдлын тухай хууль 7 дугаар зүйл. Яамны нийтлэг эрхлэх асуудал 7.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг ажил эрхэлнэ: 7.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; Төрийн хяналт шалгалтын тухай хууль 9 дүгээр зүйл.Мэргэжлийн хяналтын байгууллага, түүний бүрэн эрх 9.1.Мэргэжлийн хяналтын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд түүнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	Яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Яам (төрийн захиргааны төв байгууллага) нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах үүрэгтэй. Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1 дэх заалт “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.4.2-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг зохистой ашиглуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасантай давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.4.2 дахь заалтыг хүчингүй болгох Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг 2003 онд баталснаар Төрийн хяналтын чиг үүрэг МХЕГ-т

		шилжсэн. “Газрын хэвлийн тухай” хуульд “төрийн хяналт”-ыг холбогдох яамд, тухайн орон нутгийн ИТХ, ЗД хэрэгжүүлэхээр байгаа бол бусад хуулиудад МХЕГ хэрэгжүүлэхээр хуульчилсан нь зарим талаар зөрчилтэй байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.4.1 дэх заалтыг хүчингүй болгох
7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх 1. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлого, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих; 2/ энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээний дотор аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах; 2/ нутаг дэвсгэртээ хийгдсэн геологийн судалгааны болон нутаг дэвсгэртээ оршиж байгаа ашигт малтмалын талаархи мэдээллийг зохих журмын дагуу холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч танилцах;	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль 18 дугаар зүйл. Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх 18.1. Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 18.1.1. Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар: 3/ хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ өгөх; 19 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх 19.1. Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	“Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалтууд нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 18.1.1, 20.1.1, 20.1.2 дахь заалтуудтай “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, энэ асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх” гэж агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалтуудыг тус тус хүчингүй болгох “Газрын хэвлийн тухай” хуулийн 7.2.1 дэх заалт ЗЗНДНТ хуулийн 29.1.3.г дэд заалттай агуулгын хувьд ижил байна. Санал: Газрын хэвлийн тухай хуулийн 7.2.1 дэх заалтын хүчингүй болгох

3/газрын хэвлийг ашиглах, хамгаалах ажилд хяналт шалгалт хийх; 4/энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тохиолдолд газрын хэвлийг ашиглах эрхийг хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор дуусгавар болгох; 5/газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох; 6/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>	20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх 20.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 18.1.1."е", 18.1.1."ж", 18.1.2."г", 18.1.2."ж", 18.1.2."з", 18.1.3."в", 18.1.3."г", 18.1.3."ж", 18.1.3."з", 18.1.3."к", 18.1.3."л", 18.1.3."н"-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цагт хэрэгжүүлж болохоос гадна дараахь асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 20.1.1.Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэлийг хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх; 20.1.2.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, үүнтэй холбогдох асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын илтгэл, саналыг хэлэлцэх;	
8 дугаар зүйл.Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх 1.Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлого, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих; 2/энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар сум, дүүргийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх.	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль 18 дугаар зүйл. Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх 18.1.Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд	“Газрын хэвлийн тухай” хуулийн 8.1.1, 8.1.2 дах заалтууд ЗЗНДНТ хуулийн 181.1.3 дэд заалттай агуулгын хувьд ижил байна. Санал: Газрын хэвлийн тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.2.1, 8.2.4 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгох

2.Сум, дүүргийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах; 2/нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газар олгох; 3/ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 4/ердийн ашигт малтмал, газар доорхи цэнгэг усыг ашиглах тухай саналыг холбогдох байгууллагад тавих; 5/ердийн ашигт малтмалын ордыг зохистой ашиглах болон газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулахад хяналт тавих, засаж тохижуулсан газрыг хүлээн авах; 6/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>	дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 18.1.1.Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар: 3/хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ өгөх; /Энэ дэд заалтад 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх 29.1.3. хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, газар, байгалийн бусад баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах талаар: /Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ н/нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 17 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн	
--	--	--

	амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;	
9 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашиглагч 1.Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглаж болно. 2.Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>		
10 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглах зориулалт 1.Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгоно: 1/геологийн судалгаа хийх; 2/ашигт малтмал олборлох; 3/ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах; 4/аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах. 2.Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/</u> 3.Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/</u>		
11 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашигласны төлбөр 1.Газрын хэвлийг төлбөртэй ашиглана.		

2.Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно.		
12 дугаар зүйл.Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох 1.Геологийн судалгаа хийх /геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлыг судлан ордыг илрүүлж үнэлгээ өгөх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодруулах зэрэг/-эд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох асуудлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ. 2.Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ. /Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	15 дугаар зүйл. Тойм судалгаа 15.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн этгээд тойм судалгааг тусгай зөвшөөрөлгүй явуулж болох бөгөөд судалгаа явуулах талбай, түүний байршил, өөрийн нэр, хаягийг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж бүртгүүлнэ. 15.2.Тойм судалгааны явцад газрын хэвлийг хөндөхийг хориглох бөгөөд уг газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас тухайн талбайд нэвтрэн орох зөвшөөрөл авна. 4.1.5.”ашигт малтмал эрэх” гэж ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг; 4.1.6.”ашигт малтмал хайх” гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг;	“Газрын хэвлийн тухай” хуулиар геологийн судалгаа хийхийг газрын хэвлийг ашиглах ойлголтод хамруулж байгааг нь Ашигт малтмалын тухай хуулиар болон бусад салбар хуулиар тодорхойлсон “ашиглах” ойлголт адилтгах төөрөгдөл үүсгэж ирсэн байдаг. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад эрлийн эрхийг үндсэндээ хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгож байгаа бөгөөд Ашигт малтмалын тухай хуулиар эрэл болон хайгуулын ажлыг тус тусад нь ялгавартайгаар тодорхойлсон. Ашигт малтмалын тухай хуульд тойм судалгааг тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхээр тусгасан. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн нэр томьёол хэсэгт дурдагдсан ашигт малтмал эрэх, хайх гэсэн агуулга нь “Газрын хэвлийн тухай” хуулийн геологийн судалгаа хийх гэсэн агуулгатай ижил байна. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар тойм судалгаа хийх, эрэх, хайх зөвшөөрлийг ашигт малтмалын асуудал хариусан төрийн захиргааны байгууллагаас олгож байгаа нь “Газрын хэвлийн тухай” хуультай зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 12.1, 12.2-г тус тус хүчингүй болгох
13 дугаар зүйл.Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох		

Уурхайн эдэлбэр олгосон тухай актыг үндэслэн ашигт малтмалыг олборлоход зориулан газрын хэвлийг олгоно. 14 дүгээр зүйл. Ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u>		
15 дугаар зүйл. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгох 1. Ашигт малтмал олборлох, газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахаас өөр зориулалтаар ашиглуулахаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно: 1/улсын болон аймаг, нийслэлийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга; 2/орон нутгийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн сум, дүүргийн Засаг дарга. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан барилга байгууламжийн ажлыг эхлэхдээ тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ. 3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй. 4. Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах зориулалттай барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг тухайн аймаг,	Хог хаягдлын тухай хууль 20 дугаар зүйл. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хориглох үйл ажиллагаа 20.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараахь хог хаягдал булшлахыг хориглоно: 20.1.1. аюултай хог хаягдал; 20.1.2. халдвартай хог хаягдал; 20.1.3. шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал. 4.1.2. “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг; 34.9. Доорхи төрлийн хог хаягдлыг ландфиллд булшилж устгахыг хориглоно: 34.9.1. шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал; 34.9.2. хүн, малын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эмчилгээ, сувилгаанаас үүссэн, эрүүл мэндийн байгууллагаас халдваргүйжүүлээгүй хог хаягдал; 34.9.3. савлагаагүй шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал; 34.9.4. судалгаа, шинжилгээ, сургалтын явцад үүссэн, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл нь тогтоогдоогүй шинэ, эсвэл шинж чанар нь судлагдаагүй химийн бодисын хаягдал;	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдсан байна. Энэхүү хуулиар зарим төрлийн хог хаягдлыг булж устгах, ландфилд булшлахыг хориглосон байна. Иймд “Газрын хэвлийн тухай” хуульд зарим бодисыг булах тухай зохицуулалт орсон байгаа нь Хог хаягдлын тухай хуультай нийцэхгүй байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын хуулиудад улсын болон аймаг, нийслэлийн чанартай барилга байгууламж гэсэн нэр томъёо байхгүй байна. Барилга барих газрын эрхийг төсөвт байгууллагад Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-т заасны дагуу Засаг даргын шийдвэрээр, бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 33.1.2-т заасны дагуу дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтаар олгож байна. Мөн Газрын тухай хуулийн 34.1-д заасны дагуу газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших

нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно. 5.Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг булах, бохир ус зайлуулахдаа эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон тусгай нөхцөл, шаардлага хангасан байвал зохино. 6.Хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ. 7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зориулалтаар газрын хэвлийг ашиглуулахыг Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд газрын хэвлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно. Гүйцэтгэгч байгууллага нь хортой бодисыг хамгаалан булснаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ. /Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	34.9.5.хоорондоо нийцгүй хог хаягдлыг нэг дор, нэг үүрэнд хамт булшлах. 34.10.Дараахь чөлөөт шингэн агуулсан савыг ландфиллд булшилж устгаж болно: 34.10.1.чөлөөт шингэнийг зайлуулсан, шингээгчид шингээсэн эсвэл хатууруулж бэхжүүлсэн; 34.10.2.тавин миллитрээс бага савлагаатай; 34.10.3.шингэн хадгалах зориулалтгүй, шингэн болон түүнийг агуулсан сав нь хамтдаа нэг зорилгоор ашиглагддаг батарей, аккумулятор зэрэг шингэн агуулсан сав; 34.10.4.нэг литрээс бага хэмжээтэй давхар савлагаатай шингэн. 34.11.Энэ хуулийн 34.10-т зааснаас бусад бүх төрлийн шингэнийг ландфиллд булшлахыг хориглоно. 34.12.Хоосон савыг ландфиллд булшлахад эзлэхүүний 90-ээс багагүй хувийг хогоор дүүргэж эсвэл жижиглэж, буталж эзлэхүүнийг нь багасгасны дараа булшилна. 34.13.Жижиг савлагаатай аюултай хог хаягдлыг (химийн бодис) зориулалтын саванд давхар савлаж, ландфиллд булшилж болох ба энэ хуулийн 7.1.2-т заасан журмын шаардлагыг хангасан байна. 8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 8.1.Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11 дүгээр зүйл. Мэдээллийн нэгдсэн сан 11.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хог хаягдлын мэдээллийн нэгдсэн сантай, аймаг, нийслэл,	гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ. Газрын тухай хуулийн 16.1.14-т зааснаар аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарах ба энэ зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг Засгийн газар гаргахаар зохицуулсан нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 15.6-тай давхардаж байна. Хог хаягдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хог хаягдлын мэдээллийн сан, бүртгэлийн асуудлыг зохицуулсан байх тул “Газрын хэвлийн тухай” хуулийн 15.7-д заасантай давхардаж байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 15.4-15.7 дэх хэсгүүдийг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэх “Газрын хэвлийн тухай” хуулийн 15.6, 15.7-г тус тус хүчингүй болгох
--	---	--

	сум, дүүрэг хог хаягдлын мэдээллийн дэд сантай байна. 11.2.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэлийн дугаар олгож, мэдээллийн санд бүртгэнэ. 11.3.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ. 11.4.Сум, дүүрэг энгийн хог хаягдлын мэдээг аймаг нийслэлд, аймаг нийслэл хог хаягдлын нэгдсэн мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ. 11.5.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг энэ хуулийн 8.1.3-т заасан журмаар зохицуулна. Газрын тухай хууль 16 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газар 16.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна: 16.1.14.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар. 18 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 18.1.Засгийн газар газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.2.энэ хуулийн 16.1.5, 16.1.6, 16.1.7, 16.1.8, 16.1.13, 16.1.14-т заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох, эрх бүхий байгууллагын мэдэлд шилжүүлэх;	
--	---	--

18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ердийн ашигт малтмал олборлох, газар доорхи цэнгэг усыг ашиглах эрх Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн уурхайн эдэлбэр авахгүйгээр ердийн ашигт малтмал олборлох, газар доорхи цэнгэг усыг ашиглах эрхтэй.	Усны тухай хууль 28 дугаар зүйл. Ус ашиглагчид олгох зөвшөөрөл 28.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ энэ хуулийн 28.4-т заасан этгээдэд гаргана. 28.4. Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана. 28.6. Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 12 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлага 12.1. Ашигт малтмалын тухай хуулийн 17.1-17.3-т заасан шаардлагыг биелүүлнэ. 12.2. Нэг тусгай зөвшөөрлөөр олгох түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ Ашигт малтмалын тухай хуулийн 17.4-т заасны дагуу 25 гектараас багагүй, 400 гектараас ихгүй байна. Ашигт малтмалын тухай хууль 7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.	“Газрын хэвлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд газар доорхи цэнгэг усыг ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийг авахаар тусгасан ба Усны тухай хуулийн 28 дугаар зүйлд ус ашиглагч нь аж ахуйн зориулалтаар ус ашиглах зөвшөөрлийг ашиглах усны хэмжээнээс хамаараад өөр өөр этгээдээс авах тухай заасан байна. Иргэн аж ахуйн нэгжид энэ төрлийн зөвшөөрлийг өгөх субъект нь давхардсан байна. Ашигт малтмалын тухай хуулийн 3.1-д зааснаар тус хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна. Мөн тус хуулийн 7.3-т зааснаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн уурхайн эдэлбэр авахгүйгээр ердийн ашигт малтмал олборлох, газар доорхи цэнгэг усыг ашиглах эрхтэй гэж” заасан нь Ашигт малтмалын тухай хуультай зөрчилдөж байна.
---	---	---

		Санал: Газар доорх ус ашиглах зөвшөөрөл өгөх асуудал нь Усны тухай хуулиар нарийвчлан зохицуулагдаж байгаа тул Газрын хэвлийн хуулийн 18 дугаар зүйлийг хүчингүй болгох
19 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашиглах хугацаа 1.Газрын хэвлийг хугацаагүй буюу хугацаатайгаар ашиглалтад олгож болно. 2.Газрын хэвлийг урьдчилан тодорхой хугацаа тогтоолгүйгээр ашиглалтад олгосон бол хугацаагүй түрээслэн ашиглах гэнэ. 3.Газрын хэвлийг ашиглалтад хугацаатай олгох нийт хугацаа 30 жилээс илүүгүй байна. Шаардлагатай бол тогтоосон хугацааг газрын хэвлийг түрээслэн ашиглуулахаар анх олгосон байгууллагын шийдвэрээр сунгаж болох бөгөөд нэг удаад сунгах хугацаа 20 жилээс дээшгүй байна. 4.Ашигт малтмалын ордыг ашиглах, хугацааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>	Ашигт малтмалын тухай 21.1.5.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар 3 удаа сунгуулах; 26.5.Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 26.3.2, 26.3.3-т заасны дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгож, тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ. 27.1.7.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг ашигт малтмалын нөөцийн хэмжээнээс хамааран 20, 20 жилээр сунгуулах;	Дээр дурдсан хуулиудын газрын хэвлийг ашиглах хугацаа заасан зохицуулалтууд зөрчилдөж байна. Санал: Газрын хэвлийг ашиглах хугацааны талаар хуулиудын зохицуулалтыг хооронд нь нийцүүлэх, “Газрын хэвлийн тухай” хуулийн 19.4-г хүчингүй болгох
21 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох үндэслэл, журам 1.Газрын хэвлийг ашиглах эрхийг дор дурдсан тохиолдолд бүрэн буюу хэсэгчлэн дуусгавар болгоно: 1/газрын хэвлийг цаашид ашиглах шаардлагагүй болсон; 2/газрын хэвлийг ашиглахаар тогтоосон хугацаа дууссан; 3/төрийн буюу олон нийтийн бусад хэрэгцээнд зориулан газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гарсан;	56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах 56.1.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр цуцална: 56.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон; 56.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн 34.7-д заасан хугацаанд нь бүрэн төлөөгүй; 56.1.3.хайгуулын болон уурхайн талбайг энэ хуулийн 13.1.3-т заасны дагуу нөөц болон тусгай хэрэгцээнд авч, эсхүл тухайн талбайд	Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар тусгасан. “Газрын хэвлийн тухай” хуулийн 6.3.4-т УУХҮЯ ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгохоор заасан байна. Харин Ашигт малтмалын тухай

4/газрын хэвлийг ашиглаж байсан аж ахуйн нэгж, байгууллагыг татан буулгасан; 5/хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон. 2.Хэрэв газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан зөрчил гаргавал газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгож болно: 1/газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй; 2/газрын хэвлийг олгосон зориулалтаас өөрөөр ашигласан; 3/энэ хуулийн 20 дугаар зүйлийн шаардлагыг биелүүлээгүй; 4/газрын хэвлийг ашиглах, хамгаалах бусад журмыг өөр хэлбэрээр ноцтой зөрчсөн. 3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд газрын хэвлийг аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан ашиглах талаар тогтоосон журам, нөхцөлийг зөрчвөл газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуусгавар болгож болно. 4.Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох өөр үндэслэлийг Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоож болно. 5.Газрын хэвлийг ашиглах эрхийг уурхайн эдэлбэр олгосон тухай акт буюу газрын хэвлийг ашиглуулах тухай зөвшөөрөл олгосон байгууллага нь акт буюу зөвшөөрлөө хүчингүй болгох замаар дуусгавар болгоно.	ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн; 56.1.4.тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардал нь энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс бага бол; 56.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан; 56.1.7.хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон. 56.1.8.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн. 56.1.9.Энэ хуулийн 49.1, 49.2, 49.3-т заасныг зөрчиж тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн бол; 56.1.10.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 49.4.8, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.8, 30.6-д заасан аргачлалын дагуу холбогдох татварыг тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан; 56.1.11.Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй бол.	хуульд уурхайн эдэлбэр олгох зохицуулалт тусгагдаагүй. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 21.5-д заасны дагуу “Газрын хэвлийг ашиглах эрхийг уурхайн эдэлбэр олгосон тухай акт олгосон байгууллага нь акт буюу зөвшөөрлөө хүчингүй болгох замаар дуусгавар болгоно” гэсэн агуулга нь УУХҮЯ-наас шийдвэр гаргахаар ойлгогдож байгаа нь Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг АМГТГ-аас цуцлах тухай Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 21.5-н “уурхайн эдэлбэр олгосон тухай акт буюу” гэснийг хасах
22 дугаар зүйл.Газрын хэвлийн геологийн судалгаа хийхэд тавих үндсэн шаардлага Газрын хэвлийн геологийн судалгаа хийж байгаа Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага болон	16.2.Геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хуримтлал байж болох хэтийн төлөв бүхий талбайг тогтоох зорилгоор геологийн судалгааг шинжлэх ухааны үндэслэл бүхий арга,	

бусад байгууллага дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино: 1/геологийн судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой, зөв зохистой, үр ашигтай хийх; 2/газрын хэвлийн геологийн тогтоц, түүнчлэн хайгуул хийсэн ордыг ашиглах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад нөлөөлдөг гидрогеологи, уул-техникийн болон бусад нөхцөлийг бүрэн судлах; 3/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийг бүрэн илрүүлж, тэдгээрийн нөөцийн хэмжээ, чанар боловсруулах технологийг үнэн зөв тодорхойлох, ашигт малтмалын ордод геологи-эдийн засгийн үнэлгээ өгөх; 4/геологийн судалгааны ажлыг ашигт малтмалын чанарыг бууруулахгүй, зүй бус хаягдал гаргахгүй аргаар хийх; 5/газрын хэвлийгээс гаргасан чулуулаг, ашигт малтмалыг байгаль орчинд хортой нөлөө үзүүлэхгүйгээр хадгалж хамгаалах, тэдгээрийг цаашид ашиглах нөхцөлийг бүрдүүлэх; 6/ордыг ашиглах үед болон аж ахуйн бусад зориулалтаар ашиглаж болох хайгуулын малталт, өрөмдлөгийн цооногийг хүн, мал, ан амьтанд аюулгүйгээр бүрэн бүтэн байлгах, харин ашиглахгүй хайгуулын малталт, өрөмдлөгийн цооногийг дарж цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан тухайн сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгч, геологийн судалгааны ажлын дүнгээ мэдээлж бүртгүүлэх; 7/газрын хэвлийг цаашид судлах, ашигт малтмалын ордыг хайх, ашиглах, түүнчлэн газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглахад хэрэглэж болох геологийн болон гүйцэтгэл-техникийн баримт бичиг, чулуулаг, хүдрийн дээж, цооногийн чөмөг,	аргачлалын дагуу, тодорхой үе шаттайгаар гүйцэтгэнэ.	
---	---	--

ашигт малтмалын сорьцын хувийг бүрэн бүтэн байлгах.		
23 дугаар зүйл.Газрын хэвлийн геологийн судалгааны ажлын улсын тоо бүртгэл 1.Газрын хэвлийн геологийн судалгааг зэрэгцэн хийхгүй байх зорилгоор геологийн судалгааны ажлыг улсын бүртгэлд бүртгэнэ. 2.Улсын бүртгэлд бүртгүүлэлгүйгээр геологийн судалгаа хийхийг хориглоно. 3.Газрын хэвлийн геологийн судалгааны үр дүнг нэгтгэн ашиглах зорилгоор геологийн судалгааны ажлын үр дүн, уг ажлын явцад илрүүлсэн ашигт малтмалын орд, илрэлийн улсын тоо бүртгэл хөтөлнө.	Ашигт малтмалын тухай хууль 48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах 48.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө. /Энэ хэсгийг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ 48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.	“Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын нөөц” гэсэн нэр томъёог 1997 оны Ашигт малтмалын тухай хууль батлахаас өмнө “геологийн судалгааны ажлын үр дүн, ашигт малтмалын орд, илрэл” гэж Газрын хэвлийн хуульд тодорхойлсон ба энэ нь одоо мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хуультай нэр томъёоны хувьд зөрчилтэй байна. Харин хайгуул хийгдсэн ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн нэгдсэн тайланг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ гэсэн нь агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 23.3 дах хэсгээс “уг ажлын явцад илрүүлсэн ашигт малтмалын орд, илрэлийн улсын тоо” гэснийг хасах
24 дүгээр зүйл.Эрдэс түүхий эдийн жишиг 1.Ордын үйлдвэрлэлийн үнэт чанарыг тодорхойлох, түүний ашигт малтмалын нөөцийг тооцохын тулд эрдэс түүхий эдийн жишгийг орд тус бүрээр тогтооно. Энэхүү жишиг нь ашигт малтмалын хэмжээ, чанар ордыг ашиглах уул-геологийн болон бусад нөхцөлд тавих эдийн засгийн үндэслэл бүхий шаардлагын цогц байвал зохино. 2.Эрдэс түүхий эдийн жишгийг үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүнчлэн тэдгээрт байгаа үнэт бүрэлдэхүүн хэсгийг бүрэн гүйцэд ашиглахаар тооцож боловсруулан батлуулна.	48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах 48.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө. 48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс	“Газрын хэвлийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлд заасан тайлан нь Ашигт малтмалын тухай хуулийн Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлантай агуулга буюу тус хуулийн 48.3, 48.4-тэй агуулгын хувьд давхардаж байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийг хүчингүй болгох

	мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.	
АШИГТ МАЛТМАЛЫГ ОЛБОРЛОХ, ЭРДЭС ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БОЛОН АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХООС ӨӨР ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ДООР БАРИХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОХ, ТЭДГЭЭРИЙГ БАРИХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ 27 дугаар зүйл.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох 1.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төслийг тэдгээрийг барихаар төлөвлөж байгаа талбайн газрын хэвлийн геологийн болон бусад судалгааны материалыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан зохионо. 2.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төслийг гагцхүү ашигт малтмалын нөөцийг нь баталж, ордыг үйлдвэрийн ашиглалтад зориулан шилжүүлж, ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг нь баталсны дараа зохионо. Онцгой шаардлага гарвал ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын зураг төслийг Засгийн газрын зөвшөөрснөөр ашигт малтмалын нөөц батлахаас өмнө зохиож болно.		“Газрын хэвлийн тухай” хуулийн 27.2-т заасан зохицуулалт нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулах харилцаа байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 27.2-г хүчингүй болгох

/Энэ хэсгийн сүүлчийн өгүүлбэрийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ 3.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн байршлыг тэдгээрийн зураг төслийн ажил эхлэхээс өмнө зохих нутгийн захиргааны байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагатай тохиролцоно.		
28 дугаар зүйл.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага 1.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төсөлд дор дурдсан үндсэн шаардлагыг тусгасан байвал зохино: 1/газар дээрх болон доорхи үйлдвэрийн газрын барилга байгууламжийн байршлыг ашигт малтмалын нөөцийг үр ашигтай, зөв зохистой ашиглах шаардлагад нийцүүлэн тогтоох; 2/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмалын нөөц, тэдгээрт байгаа үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг газрын хэвлийгээс эдийн засгийн хувьд илүү зохистой, гүйцэд гаргаж авах шаардлагыг хангахуйц ашигт малтмалын ордын нөөцийг олборлохоор нээх арга, ашиглах системийг сонгож тогтоох; 3/ашигт малтмал олборлох тэргүүний техник технологийг нэвтрүүлэх; 4/ашигт малтмалын ордыг ашиглах үед үржил шимтэй хөрсийг тусгайлан хуулж ашиглах буюу хадгалах, уулын малталтын чулуулгийг зөв зохистой ашиглах; 5/үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, түүнчлэн ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн авч хадгалж хамгаалах;		“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2 дахь хэсэгт Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна гэж заасан боловч тус хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд Ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрийн зураг төслийн талаар зохицуулсан нь хуулийн дотоод зөрчилтэй байна. Гэхдээ уг асуудал Ашигт малтмалын тухай хуульд тусгагдаагүйг анхаарах хэрэгтэй. Санал: Ашигт малтмал олборлох болон боловсруулах үйлдвэрийн газрын барилга байгууламжийн зураг төсөл зохиох асуудлыг Ашигт малтмалын тухай хуульд ишлэл хэлбэрээр оруулах эсхүл хүчингүй болгож Ашигт малтмалын тухай хуульд нэмэх

6/ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг барих, ашиглах явцад газрын хэвлийд геологийн судалгаа хийж геологи, маркшейдерийн баримт бичгийг бүрдүүлэх; 7/хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлийн болон байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах.		
29 дүгээр зүйл.Эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага 1.Эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл энэ хуулийн 28 дугаар зүйлийн 7-д зааснаас гадна дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино: 1/олборлосон эрдэс түүхий эдээс үйлдвэрийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авч чадахуйц технологи хэрэглэх; 2/боловсруулалтын хаягдлыг бүрэн гүйцэд ашиглах; 3/ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалж хамгаалах. 2.Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барих, ашиглалтад оруулахдаа энэ зүйлийн холбогдох заалт болон энэ хуулийн 20 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байвал зохино.		УУХҮЯ-аас хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулж байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага нь тус хуулийн зохицуулах зүйлд хамаарна. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 29.1 дэх хэсгийг тус хуулийн зохицуулалтад нэмэх
30 дугаар зүйл.Барилга байгууламж барих, ашиглахад тавих үндсэн шаардлага Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг энэ хуулийн 28, 29		

дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй зураг төслөөр барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглалтад оруулахыг хориглоно.		
31 дүгээр зүйл.Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам 1.Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана. 2.Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын техник ашиглалтын журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална. 3.Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг бохирдуулсан, түүний баялгийг зүй бусаар ашигласан, гэмтээж сүйтгэсэн зэргээс учирсан хохирлыг арилгах үүрэгтэй. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>		“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2-т зааснаар “Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна”. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 31 дүгээр зүйлийг хүчингүй болгох
32 дугаар зүйл.Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад тавих үндсэн шаардлага /Энэ зүйлийн гарчгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахдаа дараахь үндсэн шаардлагыг хангасан байвал зохино: <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> 1/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүний үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг үр ашигтай иж бүрэн, бүрэн гүйцэд олборлох аргыг хэрэглэх; 2/ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг нь сорчлон олборлохгүй байх; 3/ашигт малтмалын ордод хийвэл зохих гүйцээх болон ашиглалтын хайгуул, геологийн бусад ажил,	Ашигт малтмалын тухай хууль 35.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно. 39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 39.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ: 39.1.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;	“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2-т зааснаар “Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна”. “Газрын хэвлийн тухай” хуулийн 32.1 Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-тай давхардсан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 32.6 Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.4.3-тай давхардсан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 32.8 Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.3-тай давхардсан байна.

түүнчлэн ашиглалтын геологи, маркшейдерийн ажлыг бүрэн гүйцэтгэж, техникийн зохих баримт бичгийг гүйцэд хөтлөх; 4/ашигт малтмалын нөөцийн байдал, хөдөлгөөн, хаягдал, бохирдлыг тооцож байх; 5/уулын ажлын явцад ашиглаж байгаа болон түүнтэй зэрэгцэн оршиж байгаа ордыг гэмтээхгүй байх, нөөцөд үлдээсэн ашигт малтмалыг хадгалж хамгаалах; 6/үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалах; 7/уулын малталтын чулуулаг, үржил шимтэй хөрс, үйлдвэрлэлийн хаягдлыг зөв зохистой ашиглах байршуулах; 8/ажиллагчид болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ордыг ашиглаж дууссаны дараа тогтоосон журмын дагуу дарах буюу улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах.	39.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах; 39.1.4.байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ хуулийн 39.1.3-т зааснаас гадна дараахь зүйлийг тусгах: 39.1.4.3.уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах; 48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах 48.6.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т заасны дагуу. 48.7.Энэ хуулийн 48.6.3-т заасан тайланд дараахь зүйлийг тусгана: 48.7.1.ажилласан өдөр, ажиллагсдын тоо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлтэй холбоотой гэрээ, хэлцэл; 48.7.2.уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, нөөцийн хөдөлгөөний тооцоо, уурхай ажилласан хугацаа, үйлдвэрлэлийн дамжлагын схем, өргөтгөл, шинэтгэлийн ажил; 48.7.3.олборлосон хүдэр, үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулсан үнэ, түүнийг худалдан авагчийн тухай мэдээлэл, тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн болон ашиглаж байгаа тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн тухай мэдээ; 48.7.4.энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан аюулгүй ажиллагааны талаархи мэдээ.	“Газрын хэвлийн тухай” хуулийн 32.3 Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3-тай давхардсан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 32 дугаар зүйлийг хүчингүй болгох
33 дугаар зүйл.Эрдэс түүхий эдийг боловсруулахад тавих үндсэн шаардлага		“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2-т зааснаар “Газрын хэвлийд

Эрдэс түүхий эдийг боловсруулахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино: 1/эрдэс түүхий эдэд байгаа ашигтай бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авах технологи хэрэглэх; 2/эрдэс түүхий эдийн ашигтай бүрэлдэхүүн хэсгийн ялгарцын түвшин, хэмжээг боловсруулалтын шат бүрт бүртгэж, хяналт тавьж байх; 3/эрдэс түүхий эдийн найрлага, технологийн шинж чанарыг цаашид судлан, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох; 4/эрдэс түүхий эдийг боловсруулахад гарсан хаягдлыг ашиглах; 5/ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн тооцож хамгаалж байх. 34 дүгээр зүйл.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах, нөөцөд үлдээх <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u>		ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна”. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 33 дугаар зүйлийг Ашигт малтмалын тухай хуульд шилжүүлэх
35 дугаар зүйл.Түрээслэгч нь газрын хэвлийг бусдад ашиглуулах Уурхайн эдэлбэр түрээслэгч нь ордыг үйлдвэрлэлийн аргаар ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон хэсгийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ажил гүйцэтгэх гэрээгээр ашиглуулж болно.		Уурхайн эдэлбэрийг түрээслэх гэсэн ойлголт нь 1994 оны Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан ойлголт болно. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад Уурхайн эдэлбэрийг түрээслэх гэсэн ойлголт тусгагдаагүй. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 35 дугаар зүйлийг хүчингүй болгох
36 дугаар зүйл.Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах журам 1.Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглах болон бусад ийм зорилгоор газрын хэвлийг		

ашиглахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрч баталсан зураг төслийг баримтална. 2.Зураг төсөлд үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг хор хөнөөлгүй болгох буюу тэдгээрийг тогтоосон хилийн дотор тусгайлан хадгалж хамгаалах, газрын гадарга, уулын малталт, усны объектод нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг тусгана. 3.Энэ зүйлд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон тусгай эрх бүхий төрийн бусад байгууллага нь үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газар доор хамгаалан булах буюу урсгах, хадгалахыг таслан зогсоох, хориглох үүрэгтэй.		
37 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглах ажлын аюулгүй байдлыг хангах 1.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглах, геологи хайгуулын болон газрын хэвлийг ашиглахтай холбогдсон бусад ажил гүйцэтгэхдээ хүн амын аюулгүй байдлыг хангах, ажиллагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг хангасан байвал зохино. 2.Газрын хэвлийг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүргийг тэдгээрийн эрх баригчид хүлээх бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгж бүрт уг дүрэм, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих ажлыг тодорхой ажилтанд тухайлан хариуцуулсан байвал зохино.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 7 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламжид тавих шаардлага /Энэ зүйлийн дугаарт 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ 7.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, туршилт, засвар хийх үйлчилгээ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна. 27 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт 27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.	“Газрын хэвлийн тухай” хууль батлагдсанаас хойш 2008 онд батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, Машин механизм, тоног төхөөрөмж, Өргөх, зөөх, тээвэрлэх механизм, Даралтат сав, шугам хоолой, Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, Галын аюулгүй байдалд тавих шаардлага зэргийг тус тус дэлгэрүүлэн хуульчилсан ба эдгээрийн агуулга нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 37.1 дэх хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 37.1 дэх хэсгээс “Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг болон” гэснийг хасах “Газрын хэвлийн тухай” хуулийн 37 дугаар зүйлд заасан газрын хэвлий

	27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна. 7.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, туршилт, засвар хийх үйлчилгээ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.	ашиглах үеийн аюулгүй ажиллагааг хэрэгжүүлэх субъект нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд утга агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 37.2 дах хэсгийг хүчингүй болгох “Газрын хэвлийн тухай” хууль батлагдсанаас хойш 2008 онд батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, Машин механизм, тоног төхөөрөмж, Өргөх, зөөх, тээвэрлэх механизм, Даралтат сав, шугам хоолой, Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, Галын аюулгүй байдалд тавих шаардлага зэргийг тус тус дэлгэрүүлэн хуульчилсан ба эдгээрийн агуулга нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 37.1 дэх хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 37.1 дэх хэсгийг хүчингүй болгох
38 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглах явцад аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлага 1.Газрын хэвлийг ашиглахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино: 1/аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг бүх ажилчин, албан хаагчдаар судлуулж мөрдүүлэх; 2/аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг 28.1.Ажил олгогч нь дараахь үүрэгтэй байна: 28.1.8.аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй	“Газрын хэвлийн тухай” хууль батлагдсанаас хойш 2008 онд батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.1 дэх хэсэгт заасан асуудлыг мөн адил, гэхдээ дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан байна. Иймд Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг нарийвчлан зохицуулсан

3/ажиллагчдын амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, тэднийг аюулгүй газарт гаргаж, уг нөхцөл байдлыг арилгаж хэвийн болгох шаардлагатай арга хэмжээг шуурхай авах; 4/аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирсон машин техник, тоног төхөөрөмж, материал, ажлын тусгай хувцас, бие хамгаалах бусад хэрэгслээр хангаж хэрэглүүлж байх; 5/тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зохих ёсоор бүртгэн тооцох, хадгалах, зарцуулах, аюул осолгүй хэрэглэх. 2.Уулын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь уурхайн доторхи агаарын найрлагыг сайжруулах, уулын ажлын технологи, аюулгүй ажиллагааны арга, техник хэрэгслийг боловсронгуй болгох асуудлыг тусгасан, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн техник, зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээ авч уулын ажил гүйцэтгэдэг ажилтан, албан хаагчдын аюул осолгүй, хэвийн ажиллаж, амьдрах нөхцөл болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээг байнга боловсронгуй болгож байна. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> <u>3. /Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u> 4.Уулын малталт нь газар доор ажиллаж байгаа хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохоор буюу уурхайн доторхи агаарын хүчилтөрөгч, хортой болон тэсрэх аюултай хий, тоосны хэмжээ, түүнчлэн агаарын халуун, хүйтэн нь аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирохгүй байвал уулын ажил гүйцэтгэхийг хориглоно. 5.Уулын болон тэсэлгээний ажил удирдахыг зохих тусгай мэргэжлийн ажилтанд, тэсэлгээний ажил	ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх; 27 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт 27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна. 27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна. 27.3.Энэ хуулийн 27.2-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 27.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх; 28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг 28.1.Ажил олгогч нь дараахь үүрэгтэй байна: 28.1.2.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;	тусгай хууль байгаа тул “Газрын хэвлийн тухай” хуульд зохицуулах шаардлагагүй байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.1.1-38.1.4 дах хэсгүүдийг тус тус хүчингүй болгох “Газрын хэвлийн тухай” хууль батлагдсанаас хойш 2013 онд батлагдсан Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулиар үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулах ба бүртгэлийн асуудлыг нарийвчлан зохицуулсан тул “Газрын хэвлийн тухай” хуульд зохицуулах шаардлагагүй байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.5 дахь хэсгийг хүчингүй болгох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008 онд батлагдсан. Тус хуулийн 27.2-т зааснаар Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна. Энэхүү зөвлөл нь тус хуулийн 27.3.1-д зааснаар аж
--	--	--

хийхийг тийм ажил эрхлэн гүйцэтгэх эрх бүхий хүмүүст тус тус зөвшөөрнө.	28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг 28.1.Ажил олгогч нь дараахь үүрэгтэй байна: 28.1.2.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах; 15 дугаар зүйл. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах 15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй. 15.2. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна. 15.3. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ. 15.4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулсан байна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд энэ заалт хамаарахгүй. 9.1.Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн талаар ажил олгогч нь дараахь шаардлагыг хангасан байна: 9.1.1. машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх;	ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасан нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.2-той давхардаж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.2 дахь хэсгийг хүчингүй болгох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.2-т зааснаар Ажил олгогч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах үүрэгтэй гэж заасан нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.4-тэй давхардаж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 38.2 дахь хэсгийг хүчингүй болгох
--	--	---

	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 15 дугаар зүйл.Тэсэлгээний ажил явуулахад тавих шаардлага 15.1.Тэсэлгээний ажлыг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гүйцэтгэнэ. 15.2.Тэсэлгээний ажил явуулах хуулийн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлага тавина: 15.2.1.мэргэжлийн ажиллах хүчинтэй байх; 15.2.2.цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх; 15.2.3.тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, харуул хамгаалалт бүхий тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахтай байх. 15.3.Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь мэргэжлийн хяналтын төв байгууллагаас олгосон хяналтын хуудсыг үндэслэн үйл ажиллагаа явуулна.	
39 дүгээр зүйл.Уулын ажил гүйцэтгэж байгаа хүмүүсээс аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг сахин биелүүлэх талаар гүйцэтгэх үүрэг	18 дугаар зүйл.Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Уулын ажил гүйцэтгэж байгаа хүмүүсийн үүрэг нь “Газрын хэвлийн тухай”

Уулын ажил гүйцэтгэж байгаа хүмүүс дор дурдсан үүрэгтэй байна: 1/аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний шаардлагыг чанд сахин биелүүлэх; 2/ажлын байр, тоног төхөөрөмжийг тогтмол шалган, аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг гажуудуулсан зөрчлийг нэн даруй арилгах арга хэмжээ авах; 3/ажил дээрээ тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх; 4/ажил гүйцэтгэхдээ аюул осол, золгүй тохиолдолд хүргэж болзошгүй арга хэрэглэхийг цээрлэх; 5/аюул осол гарч болох нөхцөл байдал бүрдвэл ажлаа зогсоож, энэ тухай ажил удирдаж байгаа хүнд нэн даруй мэдэгдэж, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөөг чанд баримтлан ажиллах.	18.2.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараахь нийтлэг үүрэгтэй байна: 18.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх; 18.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх; 18.2.3.хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах; 18.2.4. эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох; 18.2.5. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх; 18.2.6. ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх; 18.2.7. өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх; 18.2.8. ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.	хуулийн 18.2-той давхардаж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 39.2 дах хэсгийг хүчингүй болгох
40 дүгээр зүйл.Уул уурхайн аврах алба 1.Уулын ажлын аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах үүрэг бүхий уул уурхайн аврах албыг тусгай дүрмийн дагуу байгуулж ажиллуулна. 2.Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага энэхүү албаны үйлчилгээнд хамрагдана. 3.Уул уурхайн аюул ослоос аврах үйл ажиллагааны дүрмийг холбогдох яам, тусгай	Гамшгаас хамгаалах тухай хууль 4.1.3."осол" гэж уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг; 19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх	Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталсан. Тус хуулийн 4.1.2-т “осол” гэсэн ойлголтыг тодорхойлсон ба уул уурхайн ослыг хамааруулан тодорхойлсон. Тус хуулийн 19.1-д зааснаар Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед

газар, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцож батална. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> 4.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газарт аюул осол гарсан тохиолдолд нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харьяалал харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж, эмийн зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаврыг арилгахад шаардагдах бусад тусламж үзүүлэх үүрэгтэй.	19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. /Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ 19.2.Энэ хуулийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.	шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргах ба үүнтэй холбоотой журмыг Засгийн газар батлахаар заасан байна. Иймд “Газрын хэвлийн тухай” хуулийн 40.4 дэх хэсгийн зохицуулалт шаардлагагүй байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 40.4 дэх хэсгийг хүчингүй болгох 40.1.1-40.1.3-г Ашигт малтмалын тухай хуульд шилжүүлэх
ГАЗРЫН ХЭВЛИЙГ ХАМГААЛАХ 41 дүгээр зүйл.Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага 1.Монгол Улсын газрын хэвлий нь улсын хамгаалалтад байна. 2.Газрын хэвлийг хамгаалахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино: 1/газрын хэвлийн геологийн судалгааг иж бүрэн гүйцэд хийх; 2/газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх, түүнийг дур мэдэн ашиглах явдлыг гаргуулахгүй байх; 3/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийг зөв зохистой, иж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах; 4/ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах; 5/ашигт малтмалын ордыг усанд автах, үер, гал түймрээс болон ашигт малтмалын чанар, ордын үйлдвэрийн үнэт чанарыг бууруулах буюу түүний ашиглалтыг хүндрүүлж болох бусад хүчин зүйлээс сэргийлэн хамгаалах; 6/ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барих, уг талбайг ашиглах		

талаар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх; 7/ашиглаж байгаа болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооног, түүнчлэн газар доорхи барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг газрын хэвлий ашиглах явцад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хамгаалах. 8/газар доор нефть, хий, материалыг хадгалах, хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах үед газрын хэвлий бохиртохоос сэргийлэх. 3.Энэ зүйлд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай эрх бүхий төрийн бусад байгууллага газрын хэвлийг ашиглахыг Монгол Улсын хууль тогтоомжид заасан журмаар хязгаарлах, зогсоох буюу хориглох арга хэмжээ аван.		
---	--	--

41.¹ дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх 1.Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. 2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дэр малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 3.Газрын хэвлийг ашиглагч энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа болгож мөнгөн барьцааг сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллагад шилжүүлнэ. 4.Мөнгөн барьцааны хэмжээ, түүнийг улсын орлого болгох асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн</u>	Газрын тухай хууль 5 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах 55.2. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна. 55.3. Газрын хэвлийг ашиглагч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 7 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээ 7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. 8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 8.4.1.төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал; 8.4.2.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн; 8.4.3.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж; 8.4.4.төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмж; 8.4.5.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас	Газрын тухай хуулийн 55.2, 55.3 дахь хэсгүүдэд “газрын хэвлий ашиглагч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгүүлнэ” гэж заасан нь бичвэрийн хувьд “Газрын хэвлийн тухай” хуультай давхцсан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 41¹ дүгээр зүйлд заасан үнэлгээний асуудал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан. Харин тус хуульд заасан ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулах нь тодорхойгүй баяа. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 411 .2 дэх хэсгээс “...болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ” гэснийг хасах, тус зүйлд заасан магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулахыг тодорхойлж бусад хуульд нийцүүлэх, БОНБУ-ний тухай хуулийг ишлэх Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх” гэсэн нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 41¹.3, 41¹.4-т заасантай, 48.6.1-д “тухайн ордыг
--	--	---

	хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ; 8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ; Ашигт малтмалын тухай хууль 38.1.8.байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх. 48.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ: 48.6.1.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;	ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор” гэсэн нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 41¹.1-д заасантай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4 дэх хэсэг нь “Газрын хэвлийн тухай” хуулийн 41¹.2-т заасантай тус тус давхардсан байна. Мөн 2012 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль батлагдсан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 411.1-411.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болгох
42 дугаар зүйл.Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих нөхцөл		

1.Барилга байгууламж барих талбайн газрын хэвлийд ашигт малтмал байхгүй тухай дүгнэлтийг геологийн байгууллагаас авалгүйгээр хот, суурин газар, үйлдвэрийн цогцолбор, барилга байгууламжийн зураг төсөл зохиох буюу тэдгээрийг барихыг хориглоно. 2.Ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих, мөн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих зөвшөөрлийг гагцхүү онцгой тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Энэ тохиолдолд газрын хэвлийгээс ашигт малтмал олборлох боломжийг хангасан байвал зохино. 3.Ердийн ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих, түүнчлэн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих зөвшөөрлийн зохих нутгийн захиргааны байгууллага олгоно.		
43 дугаар зүйл.Шинжлэх ухаан, түүх, соёлын онцгой үнэт зүйлийг агуулсан газрын хэвлийн хэсгийг хамгаалах 1.Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна. Төрийн хамгаалалтад авсан газрын хэвлийн хэсгийн бүрэн бүтэн байдалд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 2.Газрын хэвлийг ашиглах явцад геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир, палеонтологи, археологийн болон шинжлэх ухаан, түүх соёлын хувьд сонирхол татах бусад зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагчид ажлаа зогсоож, энэ тухай төрийн зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.	СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ 38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа 38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. 3.1.2.“соёлын биет өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг; Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон	Дээрх хуулийн зохицуулалтууд агуулгын хувьд давхардсан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 43.1 дэх хэсэгт зааснаар Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна гэж заасан байна. Харин тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зөвхөн “шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрыг” тусгай хамгаалалтанд авахаар тусгасан ба Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын асуудлыг орхигдуулсан байна.

	үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Санал: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн хувьд онцгой үнэт зүйл бүхий газрыг тусгай хамгаалалтанд авах талаар зохицуулалт нэмж тусган, “Газрын хэвлийн тухай” хуулийн 43.1-г хүчингүй болгох Санал: Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3 дах хэсгийг “Газрын хэвлийн тухай” хуулийн 43.2-т эшлэх
44 дүгээр зүйл. Газрын хэвлийг хамгаалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэдийн оролцоо 1. Олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон нь хууль тогтоомж, дүрмийнхээ дагуу газрын хэвлийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож, төрийн байгууллагад тус дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> 2. Иргэд нь газрын хэвлийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах тодорхой санал санаачилга гаргаж, энэ талаар илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, таслан зогсоох болон төрийн байгууллагаас зохиож байгаа бусад ажилд идэвхтэй оролцож байвал зохино.		Хөдөлмөрийн хамт олон гэсэн нэр томъёог одоо хэрэглэгддэггүй, энэ байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг ойлгомж муутай байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 44.2 дахь хэсэг нь үр дагавар үүсгэхгүй байна. Мөн иргэдийн оролцооны зохицуулалтыг Захиргааны ерөнхий хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулж байгаа тул давхардуулан зохицуулах шаардлагагүй. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 44 дүгээр зүйлийг хүчингүй болгох
НАЙМДУГААР БҮЛЭГ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, ОРДЫН БОЛОН ГАЗРЫН ХЭВЛИЙН УЛСЫН ТОО БҮРТГЭЛ 45 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц, ордын улсын тоо бүртгэл 1. Ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэнэ. 2. Газрын хэвлийн геологийн судалгааг төлөвлөх, ашигт малтмал олборлох үйлдвэрийг байршуулах, ашигт малтмалын ордыг иж бүрэн, оновчтой	Ашигт малтмалын тухай хууль 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	“Газрын хэвлийн тухай” хуульд заасан “Улсын геологийн сан” гэх байгууллага байхгүй бөгөөд уг үүргийг одоогоор Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Ашигт малтмалын хайгуулын хэлтэс ба газрын тос, нүүрсний давхаргын метан хийн хайгуул хариуцсан Газрын тосны хайгуулын хэлтэс

ашиглах, түүнчлэн улс ардын аж ахуйн бусад зорилтыг шийдвэрлэх зорилгоор ашигт малтмалын ордын улсын данс хөтөлж, ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохионо. 3.Ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэл, ашигт малтмалын ордын данс, нөөцийн балансыг Улсын геологийн сан эрхлэн хөтөлнө. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/</u>	11.1.5.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах; 11¹ дүгээр зүйл.Үндэсний геологийн албаны чиг үүрэг 11¹.1.Монгол Улсын Үндэсний геологийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11¹.1.3. үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх; /Энэ заалтыг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 11¹.1.4.ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх.	Мөн Үндэсний геологийн албыг 2020 онд байгуулсан. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 45.3-г хүчингүй болгох
46 дугаар зүйл.Ашигт малтмалын ордын улсын данс Ашигт малтмалын ордын улсын данс нь үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн хэмжээ, чанар, ордыг ашиглах уул-техник, гидрогеологийн болон бусад нөхцөл, түүний геологи-эдийн засгийн үнэлгээг орд тус бүрээр, ашигт малтмалыг илрэл бүрээр нь тусган харуулсан байвал зохино.		“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2-т зааснаар Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 46 дугаар зүйлийг хүчингүй болгох
47 дугаар зүйл.Ашигт малтмалын нөөцийн улсын баланс Ашигт малтмалын нөөцийн улсын балансад үйлдвэрийн ач холбогдол бүхий орд тус бүрийн байршил, ашигт малтмалын нөөцийн хэмжээ, чанар, судалсан байдал, үйлдвэрлэлийн ашиглалтын түвшин, олборлолт, хаягдлын тухай болон хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцөөр үйлдвэрийг хэрхэн хангасныг тусган харуулна.	10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.15.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг батлах;	“Газрын хэвлийн тухай” хуулийн 10.2-т зааснаар Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.15-д зааснаар УУХҮЯ 10.1.15.геологи, уул уурхай, эрдэс

	48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.	баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг баталсан.¹⁵ Мөн тус хуулийн 111.1.3-т зааснаар Үндэсний геологийн алба үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”-ын 1.6-д зааснаар “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэгдэж дүгнэлт гаргуулсан ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг Монгол Улсын Ашигт малтмалын нэгдсэн санд бүртгэж, түүний хөдөлгөөнийг холбогдох заавар, стандартын дагуу жил бүр геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлнө”. Үндэсний Геолгийн албаны дарга Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцсэн ашигт малтмалын нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх тушаалыг гаргаж буцаан АМГТГ руу хүргүүлж байна. http://geonet.mris.mn болон http://webgis.mris.mn цахим хуудас “Газрын хэвлийн тухай” хуулийн 47 дугаар зүйлийг хүчингүй болгох
--	---	---

¹⁵ МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ. 2018 он. Дугаар А/19ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам/

48 дугаар зүйл.Ашигт малтмалын нөөцийн үнэмшлийг тогтоох Газрын хэвлийн хайгуул хийсэн ордын ашигт малтмалын нөөцийг үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг үйлдвэрлэлийн ашиглалтад бэлтгэсэн байдалд Улсын геологийн сан, мэдээллийн байгууллага магадлан шинжилгээ хийж үнэмшлийг тогтооно. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>	Ашигт малтмалын тухай хууль 10.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах; 48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.	“Газрын хэвлийн тухай” хуулийн 48 дугаар зүйлд заасан асуудал нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.4-т заасны дагуу ТЭЗҮ-г дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах байдлаар зохицуулагдаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийнА/20 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”-аар тус асуудлыг зохицуулж байна. Мөн тус журмын 4.4-т зааснаар Хайгуулын ажлаар тогтоосон ашигт малтмалын нөөцийн тооцооллыг хийхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 48 дугаар зүйлийг хүчингүй болгох
49 дүгээр зүйл.Ашигт малтмалын нөөцийг балансаас хасах Олборлосон ашигт малтмалыг, түүнчлэн үйлдвэрийн ач холбогдлоо алдсан, олборлолтын явцад хаягдсан, геологи, хайгуулын цаашдын ажлын буюу орд ашиглах явцад нотлогдоогүй ашигт малтмалын нөөцийг улсын балансаас хасах асуудлыг уг нөөцийг баталсан байгууллага шийдвэрлэнэ.	Ашигт малтмалын тухай хууль 11¹ дүгээр зүйл.Үндэсний геологийн албаны чиг үүрэг 11¹.1.4.ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх. 48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах 48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны	Ашигт малтмалын тухай хуулийн 11¹.1.4 болон 48.4-т ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх асуудлыг Үндэсний геологийн алба хариуцан ажиллаж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 49 дүгээр зүйлийг хүчингүй болгох

	үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.	
50 дугаар зүйл.Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэл Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.		
51 дүгээр зүйл.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд тавих төрийн хяналтын зорилт 1.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтын зорилт нь тус улсын яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, түүнчлэн гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүн хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журмыг сахиж, түүнийг ашиглахад аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах, сэргийлэх, уг аюул, хортой нөлөөг арилгах үүргийн биелэлтийг хангах, ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэлийн журам, түүнчлэн “Газрын хэвлийн тухай” хууль тогтоомжийн бусад заалтыг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u> 2.Газрын хэвлийн геологийн судалгаанд төрийн хяналтыг харьяалал харгалзахгүйгээр тавих бөгөөд түүний зорилт нь холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас геологийн зураглал, эрэл, хайгуул, гидрогеологи, инженер-геологи, геофизик, геохимийн болон газрын хэвлийн геологийн	Ашигт малтмалын тухай хууль 10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.8.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих; 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.14.хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих; 11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.	“Газрын хэвлийн тухай” хуульд Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу УУХҮЯ хяналт тавихаар тусгасан байхад АМТХ-д энэхүү үйл ажиллагаанд төрийн захиргааны байгууллага-АМГТГ хяналт тавихаар, УУХҮЯ зөвхөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихаар тусгасан нь хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй байна. Мөн “Газрын хэвлийн тухай” хуулиар УУХҮЯ нь ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт буюу газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгаа нь АМТХ-тай зөрчилдөж байна. 2003 онд мэргэжлийн хяналтын байгууллагыг байгуулж бүх яамдад байсан хяналтыг нэг байгууллагад буюу нэгдсэн тогтолцоонд шилжүүлсэн.

судалгааны бусад ажлыг зохих ёсоор үр ашигтай гүйцэтгүүлэхэд оршино.		АМТХ хуулийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд УУХҮЯ хяналт тавих, ажиллагаанд хяналт тавих, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар болон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналтыг АМГТГ тавих, АМТ хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг МХЕГ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад ИТХ болон ЗД, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болохоор тус тус хяналтын үүргийг бусад хуулиудад тусгасан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийг хүчингүй болгох
52 дугаар зүйл.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд хяналт тавих байгууллага 1.Геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд тус тус хяналт тавина.		АМТХ хуулийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд УУХҮЯ хяналт тавих, ажиллагаанд хяналт тавих, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар болон хайгуулын болон ашиглалтын

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Засаг дарга нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг нутаг дэвсгэртээ эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ. <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>		тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналтыг АМГТГ тавих, АМТ хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг МХЕГ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад ИТХ болон ЗД, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болохоор тус тус хяналтын үүргийг бусад хуулиудад тусгасан байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 52 дугаар зүйлийг хүчингүй болгох
53 дугаар зүйл.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх 1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дор дурдсан журам шаардлагын биелэлтийг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна: 1/ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт; 2/олборлох үйлдвэрийн газар ашигт малтмалын нөөцийг бүртгэх, балансаас цаг тухайд нь хасах талаар тогтоосон журмыг биелүүлж байгаа байдал; 3/газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлт;	Ашигт малтмалын тухай хууль 10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.8.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих; 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	“Газрын хэвлийн тухай” хуульд Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу УУХҮЯ хяналт тавихаар тусгасан байхад АМТХ-д энэхүү үйл ажиллагаанд төрийн захиргааны байгууллага-АМГТГ хяналт тавихаар, УУХҮЯ зөвхөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихаар тусгасан нь хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй байна. Мөн “Газрын хэвлийн тухай” хуулиар УУХҮЯ нь ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт

4/газрын хэвлийг ашиглахад гарч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламж, ашиглаж байгаль болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооногийг хамгаалах, аюул осолгүй байдлыг хангах арга хэмжээний биелэлт; 5/газар доор хадгалсан нефть, хий, материал, хамгаалан булсан хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус газрын гадаргад болон уулын малталт, усны объектод нэвтрэхээс сэрэмжлэн хамгаалах талаар тогтоосон журам, тавьсан шаардлагын биелэлт; 6/ашигт малтмалын орд ашиглах явцад геологи, маркшейдерийн ажил гүйцэтгэх зааврыг биелүүлж байгаа байдал. 2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан эрх эдэлнэ: 1/аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журам, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд түүнийг ашиглахтай холбогдсон ажлыг түр зогсоох; 2/газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох; 3/аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журмыг гажуудуулсан зөрчлийг арилгуулах тухай заавал биелүүлэх шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд тавьж биелэлтийг хангуулах; 4/газрын хэвлийг ашиглах явцад гарсан аюул ослын нөхцөл, шалтгааныг шалган тогтоож, түүний дүнг үндэслэн холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчдаас заавал биелүүлбэл зохих заалт, шийдвэр гаргах. 3.Засгийн газар нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих үүргийг холбогдох бусад байгууллагад хариуцуулах замаар аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журам, хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх,	11.1.14.хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих; 11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.	буюу газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгаа нь АМТХ-тай зөрчилдөж байна. 2003 онд мэргэжлийн хяналтын байгууллагыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж бүх яамдад байсан хяналт нь нэг байгууллагад буюу нэгдсэн тогтолцоонд шилжсэн. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 53 дугаар зүйлийг хүчингүй болгох
--	--	--

зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлж болно. /Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/		
54 дүгээр зүйл. Газрын хэвлийн геологийн судалгаанд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх 1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын хэвлийн геологийн судалгааны чиглэл, арга зүй, иж бүрэн байдал, чанарт хяналт тавина. 2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь геологийн судалгаатай холбогдуулан дараахь эрх эдэлнэ: 1/газрын хэвлийд геологийн судалгаа хийх үед гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар заавал биелүүлэх шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад тавьж, биелэлтийг нь хангуулах; 2/газрын хэвлийн геологийн судалгаа нь баталсан зураг төсөлд тохироогүй буюу түүнийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, түүнчлэн энэ ажлыг хийх журам, хэм хэмжээг зөрчсөн байвал түүнийг зогсоох. /Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ 3.Засгийн газар нь газрын хэвлийд геологийн судалгаа хийх хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх, зөрчлийг таслан зогсоохтой холбогдсон бусад журам тогтоож болно. /Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, биелэлтийг хангах; 10.1.2.энэ хуулийн , 20.1, 24.2, 26.9, 60.9-д заасан сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын эрх олгосноор батлах; 10.1.3.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 10.1.4.тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох; 10.1.5.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх жил бүрийн геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, төсөл, төсвийг батлах, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах; 10.1.6.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг батлах; 10.1.7.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах, бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулах;	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлд Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгасан. Тус зохицуулалтад геологийн судалгаанд улсын хяналтыг хэрэгжүүлэх эрхийг УУХҮЯ-д олгоогүй байна. Мөн тус хуулийн 11.3-т зааснаар Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэх тул Ашигт малтмалын тухай хууль болон “Газрын хэвлийн тухай” хууль зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 54 дүгээр зүйлийг хүчингүй болгох

	10.1.8.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих; 10.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах; 10.1.10.ашигт малтмал хайх, ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх. 10.1.11.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг батлах; 10.1.12.баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах; 10.1.13.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан орон тооны бус бодлогын зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлах; 10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; 10.1.15.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг батлах; 10.1.16.геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх	
--	--	--

	олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах; 10.1.17.ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг батлах; 10.1.18.үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журмыг батлах. 11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.	
55 дугаар зүйл.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтанд тавих дотоодын хяналт шалгалт 1.Яам, тусгай газар, бусад байгууллага нь тус тусын харъяа аж ахуйн нэгж, байгууллагаас газрын хэвлийг ашиглах, хамгаалах, геологийн судалгаа хийх талаар тогтоосон журмыг сахин биелүүлэх, үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсэг, эрдэс, түүхий эдийг бүрэн гүйцэд ялгаж авах, газрын хэвлийг ашиглахад аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэх, хүн амын аюулгүй байдлыг хангах, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөц, ордыг бүртгэх журам, түүнчлэн газрын хэвлийн хууль тогтоомжийн бусад заалтыг хэрхэн биелүүлж байгааг хянан шалгана. 2.Геологи, маркшейдерийн болон бусад алба нь ашигт малтмалын ордыг зөв ашиглаж байгаа эсэхэд хяналт тавина. 3.Геологи, маркшейдерийн албаны дүрмийг зохих яам, тусгай газар болон геологи, уул уурхайн	Ашигт малтмалын тухай хууль 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.14.хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих; 11.3.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.	2003 онд мэргэжлийн хяналтын байгууллагыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж бүх яамдад байсан хяналт нь нэг байгууллагад буюу нэгдсэн тогтолцоонд шилжсэн. АМТХ хуулийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд УУХҮЯ хяналт тавих, ажиллагаанд хяналт тавих, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар болон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналтыг АМГТГ тавих, АМТ хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг МХЕГ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж батална.		төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад ИТХ болон ЗД, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болохоор тус тус хяналтын үүргийг бусад хуулиудад тусгасан байна. “Газрын хэвлийн тухай” хуулийн 55.2-т Геологи, маркшейдерийн болон бусад алба нь ашигт малтмалын ордыг зөв ашиглаж байгаа эсэхэд хяналт тавихаар заасан нь Ашигт малтмалын тухай хуультай зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 55.2, 55.3 дах хэсгийг тус тус хүчингүй болгох
56 дугаар зүйл.Маргааныг хянан шийдвэрлэх харьяалал 1.Газрын хэвлийг ашиглах асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хооронд гарсан маргааныг дор дурдсан харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ: 1/нутаг дэвсгэрт нь ердийн ашигт малтмалыг олборлох зориулалтаар газрын хэвлийг ашиглах талаар болон энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан асуудлаар гарсан маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга; 2/ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын ордыг ашиглах, түүнчлэн ашигт малтмалыг олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 3/газрын хэвлийд геологийн судалгаа хийх асуудлаар гарсан маргааныг геологи, уул уурхайн		“Газрын хэвлийн тухай” хуульд маргааныг хянан шийдвэрлэх харъяаллын тухай зохицуулсан байна. Энэхүү зохицуулалт нь Ашигт малтмалын тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай зөрчилдөж байна. Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 56, 57 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгох

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага. 2.Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан эд хөрөнгийн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ. <u>/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u>		
57 дугаар зүйл.Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх журам 1.Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг аль нэг талын хүсэлтээр буюу маргаан шийдвэрлэх байгууллагын санаачилгаар энэ хууль болон Монгол Улсын хууль тогтоомжийн холбогдох бусад актад заасан журмаар хянаж шийдвэрлэнэ. 2.Маргааныг хянан хэлэлцэж байгаа байгууллага зохих материал хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт гарсан зөрчлийг арилгах талаар авах арга хэмжээг заана.		Санал: “Газрын хэвлийн тухай” хуулийн 56, 57 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгох
58 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. <u>/Энэ хэсэгт 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u> <u>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль, 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/</u>		
59 дүгээр зүйл.Хохирлыг нөхөн төлөх Газрын хэвлийн хууль тогтоомжийг зөрчсөний улмаас учруулсан хохирлыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд Монгол Улсын хууль тогтоомжид заасан нөхцөл, журам, хэмжээгээр төлнө. Албан тушаалтан болон бусад ажилтны буруугаас учирсан хохирлыг аж ахуйн нэгж,		

байгууллага нөхөн төлсөн бол гэм буруутай хүмүүст тогтоосон журмын дагуу материалын хариуцлага хүлээлгэнэ.		
60 дугаар зүйл.Газрын хэвлийг дур мэдэн ашиглах буюу ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох Газрын хэвлийг дур мэдэн ашиглах буюу ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг гаргасан зардлыг нөхөн төлөхгүйгээр зогсоож болно.		

Хавсралт 3. Монгол Улсын хуулиудад тусгагдсан хяналтын чиг үүргүүд

	АМТХ	БОНБУТХ	“Газрын хэвлийн тухай” хууль	Эрүүл ахуйн тухай хууль
УИХ	ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих			
УУХҮЯ	стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;		53 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дор дурдсан журам шаардлагын биелэлтийг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна: 1/ ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт;	
БОАЖЯ		9.12.БОМТ болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.		
ЭМЯ				9.5.Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг хамтран

				зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.
АМГТГ	хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих; хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих;	8.8.Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.		
МХЕГ	АМТ хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ	8.8, 9.12		
ИТХ, ЗД	байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;	9.12.БОМТ болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина. 8.8		
БОННУ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн эрх		15.1.3.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнг тусган боловсруулсан БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд төслийг үргэлжлүүлэх эсэх талаарх дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тавих.		
Иргэд	45.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг	18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд,		

	иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно	оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.		
--	--	--	--	--

